


Жуул



МОНГОЛЫН
АНАГААХ
УХААН

1995
№4

Монголын Анагаах Ухаан

Монгол Улсын Эрүүд Мэндийн Яам, Монголын эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн улирал тутмын сэтгүүл

36 дахь жилдээ

№4 (93)

1995 он

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Б.Саранцэцэг, П.Болормаа, М.Чүлтэмсүрэн, М.Амбага, Т.Долгосүрэн Эмийн бодисын иммун заслын үйлдлийн эрчимжилт, мембраны төлвөөс хамаарахуй.....3

Т.С.Варламова, Б.Дагвацэрэн Бөөрийг тэтгэн биеийн тамирыг сайжруулах уламжлалт жорын судалгаа.....8

Н.Төмөрбаатар Хураагуур судасны ханах бэлчрийн биоцахилгаан идэвхийг харьцуулсан судалгаа.....11

Г.Пүрэвсүрэн, Ө.Пүрэв, М.Амбага, Б.Саранцэцэг, Х.Цэрэннадмид Нарийн навчит цахилдгийн фитохими-фармакологийн судалгаа.....14

П.Батхуяг, Л.Мягмар Нумраа хунчирын бэлдмэлийн зүрх судасны системд нөлөөлөх үйлдэл.....19

ЛЕКЦ, ТОЙМ, ЗӨВЛӨЛГӨӨ

Ш.Болд, М.Амбага Судал шинжлэлийн үндсэн баримтлалын талаархи монголын уламжлалт анагаах ухааны онолын шинжлэх ухааны мөн чанарыг судлах асуудалд.....22

Б.Дагвасүрэн Хий, шар, бадганы мөн чанар ба биемахбодод хэрэгжих түгээмэл зүй тогтлууд.....26

М.Амбага, Б.Саранцэцэг “Хий, шар, бадган - мембрант байгууламж” шинэ санааны гүн ухааны зарим асуудалд.....34

Б.Энхбаяр, Ч.Долгор, Б.Дагвасүрэн Хайрст үлдийг монгол уламжлалт анагаах ухааны аргаар эмчилсэн тухай.....39

Т.Ганбаатар, Л.Мягмар Шохойн жонш, түүний бүтэц найрлага.....42

Өгүүллүүдийн англи товчлол.....44

Mongolian Medical Sciences

Quarterly journal of the Ministry Health of Mongolia and
the Scientific Society of Mongolian Physicians

36 t year of publication

No4 (93)

1995

CONTENTS

ORIGINAL ARTICLES

B.Sarantsetseg, P.Bolormaa, M.Chultemsuren, M.Ambaga,
T.Dolgormaa Influence of membrane states on the intensity of
immunotropic activity of medicaments.....3

T.S.Varlamova, B.Dagvatseren Study of traditional prescriptions
for improvement of body resistance by treating Kidney...8

N.Tumurbaatar Comparative study of the Bio-Electrical activ-
ity bloodletting points of veins.....11

G.Purevsuren, O.Purev, M.Ambaga, B.Sarantsetseg,
Ch.Tserennadmid, Z.Oyun The phytochemical and pharmaco-
logical investigation of Iris Tenuifolia Pall.....14

P.Bathuyag, L.Miagmar Pharmacological study of Astragalus
Adsurgens Pall on cardiovascular system.....19

LECTURE, REVIEWS AND CONSULTATIONS

Sh. Bold, M.Ambaga On main principals of theoretical back-
ground of pulse feeling in the Mongolian Traditional Medi-
cine.....22

B.Dagvatseren "Hii, Shar and badgan" and some basic law-
governing nature of the organism.....26

M.Ambaga, B.Sarantsetseg Philosophical problems of the new
conception "Hii, shar, badgan-membrane structure".....34

B.Enkhbayar, Ch.Dolgor, B.Dagvatseren Treatment of psoriasis
by method of Mongolian Traditional Medicine.....39

T.Ganbaatar, L.Miagmar Calctidum and it's structure and com-
position.....42

Abstracts of the articles in English.....44

ЭМИЙН БОДИСЫН ИММУНЗАСЛЫН ҮЙЛДЛИЙН ЭРЧИМЖИЛТ, МЕМБРАНЫ ТӨЛВӨӨС ХАМААРАХУЙ

**Б.Саранцэцэг, П.Болормаа, М.Чүлтэмсүрэн,
М.Амбага, Т.Долгорсүрэн**

Ардын Эмнэлгийн Хүрээлэн, Анагаах Ухааны Их Сургууль

Дархлалын эсийн (мембраны) төлвүүд нь эсийн үйл ажиллагааны идэвхид шууд нөлөөлдөг буюу энэ нь шингэн альфа төлөв давамгайлах үед эс идэвхжих, хатуу бетта төлөв ихсэх үед эсийн үйл ажиллагаа дарангуйлагдах гэсэн зүй тогтлоор илэрдгийг судлаачид үнэмшилтэй тогтоосон байдаг. (2,3,4,7,11,12,13,14)

Үүнтэй холбоотойгоор бид дорно дахин, монголын уламжлалт анагаах ухаан (МУАУ)-д янз бүрийн халдварт өвчин (9) болон биеийн тэнхээ тамир доройтон эцэж турах зэрэг дархлалын олдмол дутагдлын (ДОД) суурь дээр явагддаг өвчнүүдийн үед хэрэглэдэг байсан уламжлалтай бөгөөд туршлагын амьтдад үүсгэгдсэн ДОД-ын загвар дээр антиоксидант-мембран бэхжүүлэх үйлдлийн механизмаар иммуномодулятор үйлдэл үзүүлдэг нь бидний урьдчилсан судалгааны явцад илэрсэн шинэсэрхүү бударгана (*Salsola Laricifolia*), түмэн навчит ортууз (*Oxytropis myriophyllia*) зэрэг ургамлуудын дээрхи үйлдэл дархлалын эсийн мембраны төлвүүдийг өөрчлөн, хатуу бетта, шингэн альфа төлвийн давамгайллыг зориудаар сэдээсэн үед хэрхэн өөрчлөгдөх байдлыг харьцуулан тогтоох зорилго тавьсан юм.

Арга зүй. 18-22 гр жинтэй 100 гаруй тооны цагаан хулганыг нийт 6 бүлэгт хуваан судалгаа явуулав. 1,2-р бүлэгт холестерин (хо) 250 мг/кг, ханаагүй тосны хүчил (ХТХ)-0,1 мл (20 гр) уулган, мембраны бетта, альфа төлвийн давамгайлал сэдээсэн хяналт амьтад байсан бол 3,4,5,6-р бүлгийн амьтдад (нэг бүлэгт

ойролцоогоор 15 амьтан байсан) Хо, ХТХ-ийн оролцоотойгоор мембраны төлвийг өөрчлөхийн хамт шинэсэрхүү бударгана (ШБ), түмэн навчит ортуузын (ТНО) 10%-ын усан ханд 0,1 мл/кг, 15 мл/кг тунгаар хэрэглэв. Судалгааг хавар, намрын улиралд харьцуулан явуулав.

Туршилгын бүх бүлгийн амьтад дархлалын олдмол дутагдлын эмгэг загварыг CCL_4 (40%-0,4 мл/100 гр арьсан дор тарьж)-өөр үүсгэн, хонины цусны улаан эсийн (20%-0,5 мл судсаар) эсрэг явагдах дархлалын урвалын эрчмийг дэлүүний индекс (ДИ), дэлүүний эсийн тоо (ДЭТ), гемаглютинины таньц (ГТ), мембранд агуулагдах шиффийн суурь (ШС) зэрэг үзүүлэлтээр (1,8,10) харьцуулан тодорхойлов

Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй:

ХАВРЫН УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Холестерин хэрэглэж мембраны төлвийг өөрчилсөн хяналтын амьтдын дархлалын урвалын (ДУ) ерөнхий эрчим ханаагүй хүчил уулган мембраны төлвийг эсрэг байдлаар өөрчилсөн (1) хяналтын амьтадтай харьцуулахад дэлүүний индексийн үзүүлэлтээр 1,2 дахин, дэлүүний эсийн тоон үзүүлэлтээр 1,17 дахин, гемаглютинины таньцын үзүүлэлтээр 1,69 дахин суларсны хамт, дэлүүний эсийн мембранд агуулагдах шиффийн суурийн хэмжээ 1,2 дахин бага байсан нь дархлалан эсийн мембраны хатуу бетта төлөв нь ДУ-ын эрчимжилтийг эрс сулруулдаг тухай бусад судлаачдын (2,4) ажиглалттай нийцэж байна. Харин шинэсэрхүү бударгана, түмэн навчит ортуузын усан ханд хэрэглэсэн амьтад холестирины хэт ачаалал, бетта төлвийн ихсэлтээс нөхцөлдсөн "дархлал дутагдлын байдал" дэлүүний индексийн үзүүлэлтээр 1,6-1,88 дахин, дэлүүний эсийн тоон үзүүлэлтээр 1,2-1,35 дахин, гемаглютинины таньцын үзүүлэлтээр 1,65-2,1 дахин багасч, бэлдмэлүүд иммуностимулятор үйлдэл үзүүлж байсан нь тэдгээрийн нөлөөгөөр дархлалын эсийн мембран дээр бетта-гаас альфа шилжилт явагдан, эс идэвхжсэнийг харуулж байна. Иймд шилжилт явагдаж, эс идэвхжсэний баталгаа нь холестерин хэрэглэн мембраны бетта төлвийг нэмэгдүүлсний дараа ШБ, түмэн навчит ортуузын бэлдмэл хэрэглэсэн амьтад эрүүл үеийнхтэй харьцуулахад дэлүүний эсийн мембранд шиффийн суурийн хэмжээ 1,2-1,31 дахин нэмэгдсэн явдал юм.

Шинэсэрхүү бударгана, түмэн навчит ортуузын усан хандын

иммуностимулятор идэвхи ханаагүй тосны хүчил хэрэглэн, мембраны шингэн альфа төлөв нэмэгдүүлсэн амьтдад дээр ч илэрч, дэлүүний индекс 1,2-1,22 дахин, дэлүүний эсийн тоо 1,3-1,32 дахин, гемааглютинины таньц 1,22-1,25 дахин нэмэгдэж байсан бөгөөд харин үйлдлийн механизм нь холестерин хэрэглэж бетта төлвийг нэмэгдүүлсэн үеийнхээс өөр зүй тогтлоор илэрч байлаа.

Өөрөөр хэлбэл ханаагүй хүчил хэрэглэн, шингэн альфа төлвийг нэмэгдүүлсэн амьтдад дээр илэрч байгаа иммуностимулятор үйлдэл нь дэлүүний эсийн мембранд ӨХИП-ын бүтээгдэхүүн: шиффийн суурийн хэмжээ хяналт амьтдаас 1,21-1,5 дахин багассантай зэрэгцэн явагдаж байсан нь энэ үед бетта альфа механизм давамгайлах бус харин альфа шингэн төлвийг хэт исэлдэн задрахаас хамгаалж, тогтоон барих замаар дархлалын эсийг идэвхжүүлэх механизм зонхилон илэрч байгааг харуулж байна.

Дээрхи санаатай нийцэж байгаа өөр нэг сонирхолтой үзэгдэл бол холестерин уулгаж, мембраны бетта төлвийг нэмэгдүүлсэн амьтдад ханаагүй хүчил уулган альфа төлвийг нэмэгдүүлсэн амьтдадтай харьцуулахад эмийн бодисын үйлдлийн дор ДУ-ын эрчим анхны түвшингээсээ өсөн сэдээгдэх хурд 1,4-1,54 дахин их байсан нь бетта төлөв давамгайлах үед ДУ-ын дарангуйллын анхны түвшин өндөр байдаг боловч эрчимжих нөөц далайц сайтай, харин альфа төлөв зонхилох үед урвалын анхны эрчим өндөр байдаг боловч мембраны шингэн төлөв амархан исэлдэн задарч зарцуулагдан, эсийн идэвхжилтийн тохиромжтой төлвийн нөөц хувийн жин багасч, эмийн бодисын идэвхжүүлэх үйлдэлд хязгаарлалт үзүүлж болзошгүй байгааг харуулж байна.

НАМРЫН УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Намрын улиралд холестеринээр мембраны бетта төлвийг зориуд нэмэгдүүлсэн эрүүл амьтдад ханаагүй фосфолипидээр альфа төлвийг нэмэгдүүлсэн эрүүл амьтдадтай харьцуулахад дэлүүний эсийн тоо 1,79 дахин, дэлүүний индекс 1,41 дахин, гемааглютинины титр 1,9 дахин багассан байгаа нь дэлүүний эсийн мембран дээр идэвхигүй, царцанги бетта төлвийн хувийн жин ихэссэнтэй холбоотой юм. Түмэн навчит ортуузын (*Oxytropis myriophyllae*) бэлдмэл нь мембраны бетта төлвийг нэмэгдүүлсэн үед хяналтын амьтдадтай харьцуулахад ДЭТ-г 1,56 дахин, ДИ-ийг 1,53 дахин, ГТ-ийг 2,0 дахин, мембраны альфа төлвийг

ихэсгэсэн нөхцөлд ДЭТ-г 1,33 дахин, ДИ-ийг 1,17 дахин, ГТ-ийг 1,66 дахин ($P < 0,05$) нэмэгдүүлж байлаа. Шинэсэрхүү бударганы бэлдмэл (*Salsola Laricifolia*) мембраны бетта төлвийг нэмэгдүүлсэн тохиолдолд хяналт амьтадтай харьцуулахад ДЭТ-г 1,61 дахин, ДИ-ийг 1,24 дахин ($P < 0,05$) ДЭТ 1,11 дахин, ГТ-ийг 1,19 дахин ихэсгэж, намрын улиралд мембраны аль ч төлвийн давамгайллын үед хоёр бэлдмэл хоёулаа мэдэгдэхүйц иммуностимулятор үйлдэл үзүүлж байгаа нь ажиглагдлаа. Судалгаанд шинэсэрхүү бударганы усан хандыг 3 %-0,1 мл тунгаар, түмэн навчит ортуузын усан хандыг 1%-0,1 мл тунгаар уулган хэрэглэв. Уг туршилтын явцад анхаарал татсан нэг зүйл бол түмэн навчит ортуузын бэлдмэл нь намрын улиралд хаврын улирлын үзүүлэлттэй болон шинэсэрхүү бударганы бэлдмэлийн үзүүлэлттэй харьцуулахад маш огцом өндөр идэвхийг үзүүлсэн нь альфа+альфа механизмаар мембран шингэрч, альфа төлөв ихсэх үзэгдэл нь энэ ургамлын бэлдмэлийн иммуностимулятор үйлдэл илрэхэд тохиромжтой нөлөөлөл үзүүлдгийг харуулж байна. Өөр нэг сонирхолтой үзэгдэл бол хаврын улиралд мембраны хатуу төлвийн давамгайллын загвар дээр ТНО, ШБ-ы бэлдмэлийн иммуностимулятор үйлдэл нь ӨХИП харьцангуй ихсэлтээр, МБ дээр бетта-альфа шилжилтийг сэдээх замаар явагдаж байсан бол намрын улиралд ӨХИП-ийн эрчимжилтээр бус, харин дарангуйллын замаар буюу тэдгээрийн иммуностимулятор идэвхи нь антиоксидант үйлдлийн механизмаар явагдаж байсан нь энэ улиралд нийт биемахобод альфа төлвийн давамгайлал сэдээгдэх учраас бетта-альфа хувиралтыг ӨХИП-оор дамжуулан явуулах механизм голлох үүрэггүйг харуулж байна. Шинэсэрхүү бударгана, түмэн навчит ортуузын бэлдмэл хэрэглсэн амьтад дэлүүний эсийн тоо, индекс, гемааглютинины титр дээшлэх иммуностимулятор үйлдэл нь ӨХИП-ын хорт бүтээгдэхүүн МДА, ШС-ийн тоо хэмжээ 1,22-1,75 дахин багасах үзэгдэлтэй зэрэгцэн нөхцөлдөж явагдсан нь энэ үед дэлүүний эсийн хуваагдал хурдсах тохиромжтой нөхцөл бий болдогтой холбоотой байж болох юм. Учир нь судлаачид (Л.Ф.Дмитриев 1990) өөхний хэт исэлдэлтийн хорт бүтээгдэхүүн: малоиндиальдегид (МДА), шиффийн суурь (ШС) тоо хэмжээний хувьд хичнээн бага байх тутам эсийн митоз хуваагдал, ДНХ-ийн репликаци төдийчинээ хурдасдагийг илрүүлсэн байдаг.

1. Амбага.М. (1994) Хий, шар, бадганы онол ба мембрант байгууламж-анагаах ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол, УБ, 301 х.

2. Извекова.В.А, Туркина.Т.А., Череев.Н.А. (1988) Взаимосвязь экспрессии лимфоцитарных рецепторов простагландинами и изопротеренолом с уровнем метаболизма липидов, **Физиология человека**, Т-14, № 3, с 466-470

3. Логинов.А.С., Царегородцева.Т.М., Зотина.М.М. (1986) Иммунная система и болезни органов пищеварения, М, Медицина, 256 с.

4. Лященко.В.А. (1983) Механизм активации лимфоцитов, М, Медицина, 281 с.

5. Нарантуяа.С., Батсүрэн.Д., Батиров.В.М. (1986) Химическое изучение растении флора Монголии. Кумарины, **Химия природных соединений**, № 2, с 243-244

6. Оранский.И.Е, Царфис.П.Г. (1989) Биоритмология и хронотерапия **Высшая школа**, 159 с.

7. Петров.Р.В, Хаитов.Р.М, Атауллаханов.Р.И, (1983) Иммуногенетика и искусственные антигены, М, Медицина, 256 с.

8. Саранцэцэг.Б. (1994) Цэх галуун тавгийн нийлбэр алкалоидын фармакологийн судалгаа. АУ-ны дэд докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол,УБ, 198 с.

9. Хайдав.Ц, Алтанчимэг.Б, Варламова.Т.С., (1985) Лекарственные растения в монгольской медицине, УБ, 378 с.

10. Berkarda.В, Bouffard-Eyiiboolii.Н, Derman U, (1983) The effect of coumarin derivates on immunological system of man, **Agents and Actions**, v.13 No 1, p 50-12

11. Berlin R.D, Fera J.P (1977) Changes in membrane microviscosity associated with phagocytosis, **Proc.Nath. Acad.Sci.USA**, v.74, No 3, p 1072-1076

12. Bougnouk P.H, Sacem N, Lyonst C, (1985) Alteration in membrane acid composition of human lymphocytes and cultured transformed cells indused by interferon, **Immunology**, v.9, p 1107-1113

13. Romeo D, Cramer R, Rossi F, (1970) Use of 1-anilino-8 naphthalene sulfonate to study structural transitions in cell membrane of PMN leukocytes, **Biochemical and Biophysical Research**

14. Tursk A.J, Deltering F, Kraal G, (1981) The fatty acid composition of lymphocyte membrane and expression of homing receptors, *Immunology*, v.183, No 5, p 386-395

БӨӨРИЙГ ТЭТГЭН БИЕЙН ТЭНХЭЭ ТАМИРЫГ САЙЖРУУЛАХ УЛАМЖЛАЛТ ЖОРЫН СУДАЛГАА

Т.С.Варламова Б.Дагвац р н
Монгол улсын Эрүүл Мэндийн Яамны
Ардын Эмнэлгийн Хүрээлэн

Монгол, төвдийн уламжлалт анагаах ухаан нь биеийн илчийг сэлбэж, тамирыг сайжруулах, хөгшдийг шимжүүлэх, хүчжүүлэх эмчилгээний аргын талаар баялаг уламжлалтай юм. Энэ зорилгоор “жүдлэн” нэрийн дор олон төрлийн эмийг бүтээж хэрэглэсэн байдаг. Тэдгээр жоруудын найрлаганд ургамал (мухар цагаан, цагаан хор, хэрээн нүд, цөлийн аргамжин цэцэг, ар-үр, цээнэ г.м), амьтан (гүрвэл, мэлхий, тагтаа, могой, халиу, тарвага зэрэг амьтны мах г.м), эрдэс (жонш, мөнгөн ус, барагшун г.м)-ийн гаралтай олон эмт бодисыг оруулсан байдаг.

Эдгээр эмт бодисыг “бөөрний хүйтэн”, “бөөрний архаг”, хөл нуруу, үе гишүүн өвдөх, тамирдах, шим тэжээл дутагдсан, дуслыг сэлбэх, залуужуулах, урт наслахад тустай гэж эмийн сударт тэмдэглэжээ. Сурвалж материалаас үзэхэд дээр дурьдсан ихэнх ургамлыг нилээд тохиолдолд бөөрний өвчнийг анагаах, аливаа өвчнийг эмчлэхэд сүүлийн үе шатыг засах, буюу сүүлийг таслахад хэрэглэдэг байжээ.

“Эмийн дөрвөн үндэст” бөөрийг адилтган үлгэрлэхдээ - “хоёр бөөр нь хүний биеийг өргөсөн хүчит бөх мэт” гэж бичжээ. Энэ нь санамсаргүй зүйрлэл биш бөгөөд, уламжлалт эмнэлэгт хүний биеийн ерөнхий эсэргүүцэл, тэнхээ тамирыг бөөрний тамиртай холбоотойгоор үзэж байсан бололтой байдаг.

Бид энэ санаагаа зохих үндэслэлтэйгээр баталгаажуулахын тулд судалгааны зохих аргагүй боловсруулан ажиллаж ирлээ.

Судалгаан арга, х р гл гд хүүн:

Судалгаанд нийтдээ 20-иод нэрийн эмт бодисыг сонгон авч тэдгээрийн эмийн идэвхийг тодорхой үе шаттай тэмтрүүл

туршилтаар харьцуулан үнэлсэн. Дараа нь эм найруулах уламжлалт арга, "бүлэглэн-шаталж эм найруулах зарчим"-ыг харгалзан хэд хэдэн хувилбартай жоруудыг зохиомжлон тэдгээрийн идэвхийг харьцуулан үнэлсэн юм. Харьцуулах загвараар "бөөрний сайн" сүгмэлийг давхар сонгож сорил туршилтын бүх үе шатанд идэвхийг нь харьцуулан жишиж тодорхойлсон. Энэ удаа олон үе шаттай тэмтрүүл судалгааны дүнд сонгон авсан жорын ("Цинаспол" гэж нэрлэсэн) фармакологийн туршилт сорилын ажлын зарим дүнг авч үзлээ.

Судлагааны дүн хэлцлэг

1. Бөөрний шээс ялгаруулах үйл ажиллгааны байдалд үзүүлэх нөлөөг (1) судлахад Цинаспол эм цагаан хулганы шээсний хэмжээг 67,3 %, сүгмэл 51,8 %-иар тус тус ихэсгэж байв.

2. Агаарын хурц дутагдлын үед (2) бэлдмэл хулганы амьдрах хугацааг 28,4 %, сүгмэл 24 %-иар ($P < 0.02$) ихэсгэн антигипоксийн нөлөөтэй байлаа.

3. CCl_4 -ын хордлогонд (3) оруулсан нөхцөлд сүгмэл ба судлаж буй бэлдмэлийн амьтны үхлээс хамгаалах идэвхи нь ижил төстэй (20-30 %) ($P < 0.05$) байв.

4. Өөх тосны хэт исэлдэлтийн загвар дээр бэлдмэлийн нөлөөг судалсан туршилтын дүнгээс үзвэл Цинаспол ба сүгмэл нь CCl_4 -ын нөлөөгөөр 5 цул эрхтэнүүдэд идэвхижсэн өөх тосны исэлдэлтийн процесс эрхтэн тус бүр дээр харилцан адилгүй хэмжээгээр сааруулах үйлчилгээтэй болох нь харагдлаа.

5. Ачааллын үед бэлдмэлийн нөлөөг сэлэлтийн аргаар (4) тодорхойлох загварыг ашиглан судлахад бэлдмэл 31.0-72.0 %-иар, сүгмэл 55.9 %- хугацааг 3 дахин уртасгаж идэвхжүүлэх нөлөөтэй байв.

6. Стрессын эсрэг үзүүлэх нөлөөг имобилизаци эмгэг загвар (5) ашиглан туршиход хоёр бэлдмэл стресс урвалын явцын үед гарч ирдэг катаболик өөрчлөлтийг саатуулан хамгаалах үйлдэл үзүүлэв.

7. Цусны системд үзүүлэх нөлөөг судлахдаа чөмөг, захын цуснаас гадна (6) дэлүү тимус зэрэг лимфоид эрхтэнд гарах өөрчлөлтийг (7) үзсэн болно. Сүгмэл ба бэлдмэлийг хэрэглэсэн дүнгээс үзэхэд цус төлжилтийг идэвхжүүлэх маягийн өөрчлөлт гарч байгааг тогтоосны зэрэгцээ дархлалыг идэвхжүүлэн дарангуйллаас хамгаалах нөлөөтэй байв (8,9)

Фармакологийн харьцуулсан туршилтын үр дүн нь "Цинаспол"

шинэ бэлдмэл ба сүгмэлийн, бөөрний үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөтэй ихээхэн холбоотой гэж үзэх үндэслэл байгаа юм. Бөөр нь "биеийн 7 тамирын" нэг болох цус төлжилтийг идэвхжүүлэн зохицуулахад чухал үүрэгтэйгээс гадна өөрөө биологийн идэвхт олон төрлийн бодисын (простагландин, брадикинин, ренин, витамин Д, стероидын дааврууд г.м) солилцоог зохицуулж, физиологийн зарим тогтолцоонд (ус-ионы баланс, хүчил-шүлтийн тэнцвэр, осмосын даралтын тогтворжилт г.м) тэргүүлэх ач холбогдолтойгоор оролцдог эрхтэн юм.

Тийм учраас "бөөрний сайн" сүгмэл болон "Цинаспол" шинэ бэлдмэлийн, цус төлжилт, даржлал ба өвөрмөц бус хамгаалалтын тогтолцоог идэвхжүүлэн зохицуулах замаар биемахбодын ерөнхий тамир чадавхийг дээшлүүлж байгаа фармакологийн эдгээр үйлдэл нь уламжлалт анагаахын "бөөрийг тэтгэн биеийн тамирыг сайжруулах ёсны" нэг талын үндэслэл юм гэсэн дүгнэлт хийхэд хүргэсэн юм.

Ном зүй

1. Капура В.В., (1974) Методы первичного фармакологического исследования биологически активных веществ. М. Мед. 258 с.

2. Караваев, А., и соавторы. (1989) Антигипоксические свойства ГАМК-содержащих производных витаминов. Фармакология и токсикология. №1, с 56-58.

3. Витковская Г.А и соавт. (1974) Защитное действие некоторых дрожжевых полисахаридов при отравлении белых мышей четырёххлористым углекислым газом. Фармакология и токсикология. №5, с 619-620.

4. Дардымов. И.В., (1976) Женьшень элеутерококк. Наука. М. 201 с.

5. Селье Г., (1991) Эволюция концепции стресса. Перевод с английского. Новосибирск, с 106-107.

6. Горизонтов П.Д и соавт. (1983) Стресс и система крови. М. Медицина. с 21-22.

7. Чубарев В.Н и соавт. (1989) Иммунотропное влияние настойки из биомассы культуры ткани женьшеня и элеутерококка у мышей. с 55-58.

8. Мирониченко И.В и соавт. 1990 Различное действие тонизирующих средств на иммунный ответ. Фармакология и токсикология. №2 с. 103-108.

ХУРААГУУР СУДАСНЫ ХАНАХ БЭЛЧРИЙН БИОЦАХИЛГААН ИДЭВХИЙГ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Н.Төмөрбаатар

Анагаах Ухааны Их Сургуулийн
Монгол Уламжлалт Анагаахын Тэнхим

Монгол эмнэлгийн ханах заслын үүсэл олон мянган жилээр хуримтлагдсан мал эмнэлгийн аргуудтай нягт холбоотой юм. Эртний нүүдэлчин монголчууд түүний өвөг дээдэс малын биеийн бүтэц байгууламж эрхтэн систем, цусны судал мэдрэлийн ширхэг зэргийг нарийн судлаж мэдсэн байдгаас гадна өвчин эмгэгийн жам ёс, шинж тэмдгийг андахгүй сайн мэднэ. Монголын ард түмэн эмперик ажиглалтаар эмнэл зүйн олон арван сонирхолтой сорил туршилт явуулж байсныг сурвалж бичгээс танилцаж байхад хотонд байгаа таван хошуу мал нь эм засал судлалын томоохон бааз институт байсан мэт санаа төрүүлдэг юм. Олон мянган жилээр хуримтлагдсан мал эмчилгээний аргууд нь хүний эмнэл зүйн ухаанд аажимдаа шилжиж монгол эмнэлгийн өв сангаар арвижсаар таван заслын нэг хэлбэр болжээ. Жишил анатомын хувьд малаас улбаа авч улмаа хүний цусны судасны байрлал зүй (топографи)-г тодорхойлох болжээ. Хүнийг цээжин бие, дунд бие, бөгсөн бие гэж ерөнхийд нь гурав хуваагаад намжуун судалд ханах зориулалттай 77 бэлчир тодорхойлсноос толгой хүзүүнд 21, хоёр гарт 34, хоёр хөлд 18 хөндий (дотор бие) биеийн 4 бэлчрийг хатган нээж цус авах ба юүлэх онолын үндсийг гаргасан байдаг (1).

Ханах судлын ялгалтын тухайд судлын төвд, монгол латин нэршлийн нэг мөр болгон, өрнөдийн анагаах ухааны ойлголттой ойртуулах үүднээс хураагуур судсаар хураагдах цусны урсгал хийгээд цутгаж байгаа чиглэлээр нь (2) ханах судлын сүвийн байршлыг тогтоосон юм. Ингээд цээжин биеийн өвчинд зэчүн (*vv.jugulares externa*), ганз (*vv.cephalicae humerilii*) -ыг ханах учиртай байтал бөгсөн биеийн өвчинд лонза (*vv.saphena magna*), жиншүгийг (*vv.saphena parva*), дунд биеийн өвчинд нодга (*v.mediana cubiti*), рүтүнг (*v.antebrachii posterior*), ханахаар заагаад цаашдаа эрхтэн тус бүрийн өвчнийг засах бэлчрийн байршлыг

биеийн гадаргууд байр зүйн үндэслэлээр зааж гаргасан байдаг (1).

Хураагуур судасны ханаж цус гаргах юүлэх сүв нь хэд хэдэн онцлогтой болох нь тогтоогдлоо. Үүнд хураагуур судасны ханах сүвийн дээрхи арьсны цахилгаан эсэргүүцэл орчныхоо (сүвгүй газрын) арьсны цахилгаан эсэргүүцлээс 20-30% буурч цахилгаан дамжуулах чадвар нь өндөр болсон байлаа. Ханах орны дээгүүр боолт дамжуулах судлыг гүрийлгэж дэлгэрүүлээд ханах сүвийн цахилгаан дамжуулах чадвар нь улам өгсөж, эсэргүүцэл нь багасдаг болох нь (3) тогтоогдсон юм.

Судалгааны арга зүй:

Эрүүл 35,бөөрний архаг өвчинтэй 41, элэг цөсний архаг өвчинтэй 20, нийт 96 хүний хураагуур судасны зарим ханах бэлчрийн биоцахилгаан идэвхийг харьцуулан судалсан судалгааг Япон улсын "Neurometer" гэдэг багажаар 0-200 мкА гүйдлийн хооронд 6 в-ийн тогтмол хүчдэлээр нойтон элетрод хэрэглэн хэмжилт хийв. Хэмжих гадаргуудад нэмэлт даралт үүсгэлгүйгээр зөвхөн электродын хүндийн жингээр дарж, 2-3 секундээс, илүүгүй хугацаанд хэмжилт хийв.

Судалгааны дүн, хэлцлэг:

Харьцангуй эрүүл 20-34 насны 10 эрэгтэй 16 эмэгтэйчүүдийн хураагуур судасны ханах бэлчирт хийсэн судалгаанаас үзэхэд хамгийн их биоцахилгаан идэвхтэй бэлчир толгойд Баралз (*v.frontalis*) $78,88 \pm 3,16$ мкА, дээд мөчинд зүүн бөөр самшийн бэлчир (*v.intermeta carpeae*) $55,54 \pm 3,45$ мкА, доод мөчинд зүүн жиншүг (*v.saphena parva*) $51,14 \pm 27,76$ мкА байгаа нь эрүүл хүмүүсийн биеийн дээд дунд хэсгийн хураагуур судасны биоцахилгаан идэвхи доод биеийн биоцахилгаан идэвхийг бодвол харьцангуй их байдаг зүй тогтол ажиглагдаж байна.

Бөөрний архаг хуучтай 22-65 насны 10 эрэгтэй 21 эмэгтэйчүүдийн биеийн дээд хэсгийн намжуун судасны ханах бэлчрийн биоцахилгаан идэвхи эрүүл хүнийхээс харьцангуй өндөр тухайлбал наза (*vv.nasales externa*), $91,63 \pm 3,09$ мкА ($P < 0.01$) болж биоцахилгаан идэвхи нь ихсэж байлаа. Харин биеийн доод хэсгийн хураагуур судасны ханах бэлчрийн биоцахилгаан идэвхи статистикийн үнэн магадлалттай буурсан байлаа. Тухайлбал шилбэний булчингийн судал жиншүг (*vv.saphena parva*), баруун талдаа $36,19 \pm 2,55$ мкА ($P < 0.01$),

зүүн талдаа $39,92 \pm 2,56$ мкА ($P < 0.05$), баруун шагайн судал лонза (*v.v.sarhena magna*) $39,95 \pm 2,56$ мкА ($P < 0.05$), болж цахилгаан идэвх тус тус буурчээ.

Элэг цөсний архаг хуучтай 22-55 насны 7 эрэгтэй, 13 эмэгтэйн хураагуур судасны биоцахилгаан идэвхийг эрүүл хүмүүстэй харьцуулж хийсэн судалгаанаас үзэхэд зөчүн бэлчрийн биоцахилгаан идэвхи зүүн талдаа $73,60 \pm 5,59$ мкА, ($P < 0.01$), болж ихсэж байхад элэгний судал рүтүн (*v.antebrachii posterior*), баруун талдаа $41,39 \pm 4,16$ мкА ($P < 0.05$), болж багасахын зэрэгцээ жиншүг (*v.sarhena parva*), хосоороо ($P < 0.05$), лонза баруун талдаа ($P < 0.05$), бөөр давсаг самшийн судал хоёр талдаа ($P < 0.05$), статистикийн үнэн магадлалтай буурсан. Өвчтэй хүмүүсийн хураагуур судасны ханах бэлчрийн биоцахилгаан идэвхийн ялгаа биеийн хоёр талын хос бэлчирт эрүүл хүмүүсийнхээс ихсэх хандлагатай байлаа.

Үүнээс үзэхэд хураагуур судас зөвхөн венийн цусыг хурааж зөөвөрлөх биш, харин биемахбод биогүйдлийг урсгах, холбох зам болохын зэрэгцээ биоэнергийг бүх биемахбодид тараан түгээж биеийн хэсэг тус бүрийг холбон нэг бүхэл бүтэн цогцос болгодог хийн судлын үүргийг гүйцэтгэдэг байж болох юм.

Хураагуур судсанд агуулагдаж буй ханах бэлчрийн биоцахилгаан идэвхийг хэмжих тодорхойлох арга бий болсон нь бэлчрүүдийн биоцахилгаан идэвхийн өөрчлөлтөөр өвчний явцыг тодорхойлох, оношлох шинэ боломжийг бий болгож байна.


НОМ ЗҮЙ

1. Анагаах ухааны дөрвөн үндэс (1993) Хөх хот. 425 х.
2. Б.Дагданбазар (1995) Монгол хануурын увидас. Улаанбаатар. 95 х.
3. Н.Төмөрбаатар (1995) Ханах судлын сүв тодоройлох асуудалд. Анагах Ухааны Их Сургуулийн эрдэм шинжилгээний хурлын материал. Улаанбаатар. х. 105-108.

НАРИЙН НАВЧИТ ЦАХИЛДГИЙН ФИТОХИМИ-ФАРМАКОЛОГИЙН СУДАЛГАА

Г.Пүрэвсүрэн, Ө.Пүрэв, М.Амбага, Б. Саранцэцэг,
Х.Цэрэнадмид, З.Оюун
Ардын Эмнэлгийн Хүрээлэн

Манай орны говь нутгийн ард түмний дунд хорт хавдар, эмэгтэйчүүдийн янз бүрийн өвний үед, ялангуяа склеродерми төст эмгэгүүдийн үед хэрэглэж ирсэн аман уламжлалтай (З.Барилд, Дунговь аймгийн Өлзийт сум) боловч шинжлэх ухааны үндэстэй судалгаанд хөндөгдөлгүй үлдсэн сонирхолтой ургамжлын нэг бол Нарийн навчит цахилдаг (*Iris tenuifolia*) юм. Уг ургамал дээр явагдсан фитохимийн нарийвчилсан судалгааны явцад (1) хэд, хэдэн шинэ бодис тодорхойлогдсон бөгөөд эдгээр шинэ бодисууд дээр байнга давтагдан илэрдэг бүтцийн өвөрмөц хэсэг бол



гэсэн спектрийн бичлэг бүхий полиэфирийн бүлэг юм. Энэ ургамлыг эмчилгээнд хэрэглэж ирсэн уламжлал хийгээд Нарийн навчит цахилдагийн шинэ бодис бүр дээр илэрч байгаа полиэфирийн бүлэгтэй маш төстэй бүтэц бүхий протопиний алкалоидууд нь (*Chiazospermum erectum*) хүчтэй иммуномодулятор үйлдэлтэйг тогтоосон судалгааны материалууд (5) дээр тулгуурлан бид түүнээс ялгасан бэлдмэлүүдийн иммунотроп үйлдлийг судлах зорилго тавьсан юм.

Судалгааны арга зүй:

А.Фитохимийн судалгааны арга зүй:

Судалгаанд Дундговь аймгийн Өлзийт сумын нутгаас 1993, 1995 онд түүж бэлдсэн Нарийн навчит цахилдагийн газрын доод хэсгийг авч, нийлбэр флавоноидыг баганан хроматографийн (ТСХ) аргаар ялган, цэвэршүүлж ялгасан флавоноидын бүтэц байгууламжийг цөмийн соронзон резонансийн спектр, нил улаан спектр, масс спектрийн аргаар (7) тодорхойлов.

Б.Фармакологийн судалгааны арга зүй:

Судалгааг 18-20 гр жинтэй 100 гаруй цагаан хулганан дээр явуулж, бэлдмэлийн иммунотроп үйлдлийг тимус хамааралт тест антиген болох хонины цусны улаан эсийн (ЭБ) эсрэг явагдах дархлалын урвалын эрчимжилтээр болон дөрвөнхлорт нүүрстөрөгчөөр (CCl₄) өдөөгдсөн "дархлал дутагдлын" эмгэг загвар дээр дэлүүний эсийн тоо, дэлүүний индекс, гемааглютинины титр, эсийн мембранд агуулагдах хэт исэлдэлтийн бүтээгдэхүүн-шиффийн суурийн (ШС) концентраци зэрэг үзүүлэлтээр тодорхойлов(5). Нарийн цахилдгийн 5%-ийн усан хандыг 0,1 мл тунгаар өдөрт 2 удаа уулган судалгааг явуулав.

Судалгааны үр дүн:

А.Фитохимийн судалгааны үр дүн:

Нарийн навчит цахилдагны газрын доод хэсгээс 250 гр дээж аван 1200 мл 96 хэмийн спиртээр хандлаад, спиртэн хандаа вакуум роторт ууршуулав. Уг хандаа силикагель бүхий колонкоор дамжуулан хлороформ, хлороформметилийн спирт 100:25 холимогоор угаан нийт 41 франкцийг 10-15 мл хэмжээтэй авав. Бүх фракцуудаараа ТСХ тавьж ижил француудыг нийлүүлж дахин талсжуулах замаар 2 талстыг гарган авлаа.

Хүснэгт 1


1-р бодис. Цайвар ногоон өнгөтэй талст

M + 316

¹³ C-NMP	DMSO-д	H-NMR DMSO-д	
2-	74.67		
3	41.17		
4	1 97.93	6.89(H, dd, J=1.2	7.9Hz, H-6')
5	155.75	6.80(H, dd, J=1.2	7.9Hz, H-2')
6	90.38		
7	159.41	6.69(H, t, J=7.9,	H-5')
812	1 27.36	6.80(H, S, H-6)	
9	143.07	6.07(2Y, d, J=7.3 Hz,	CH2-)
10	103.59		
1'	125.22	5.73 (H, dd, J=37.1	13.4 Hz, H-2)

2'	115.27	3.24 (1H, dd, J=13.4	17.7Hz, H-3a)
3'	145.22	2.73 (1H, dd J=3.1	17.7Hz, H-3b)
4'	142.63		
5'	119.07		
6'	117.11		
CH ₂	102.39		

Уг бодисын масс спектр, протонуудын спектрийн судалгааг үндэслэн C₁₆H₁₂O₇ томъёотой бодис болохыг тогтоов.



Зураг 1

Хүснэгт 2


2-р бодис. Цайвар ногоон өнгөтэй талст

M + 300

¹³ C-NMP	DMSO-д	H-NMR DMSO-д	
2-	74.42		
3	40.98		
4	1 97.80		
5	159.28	7.44 (1H, dd, J=1.2	7.9Hz, H-6')
6	90.28	7.20 (1H, dd, J=1.2	7.9Hz, H-4')
7	155.64		
8	127.28	6.89 6.86 (2H, t H-3', 5')	
9	142.96	6.32 (1H, S, H-6)	
10	103.47	6.08 (1H, d, J=8.5 Hz, -CH ₂ -)	
1'	124.29	5.73 (1H, dd, J=3.1 12.8 Hz, H-2)	
2'	154.22	3.29 (1H, dd, J=3.1	17.1Hz, H-3a)
3'	115.37	2.75 (1H, dd J=3.1	17.1Hz, H-3b)
4'	129.44		
5'	119.00		

6'	126.97
CH ₂	102.29

Уг бодисын масс спектр, протонуудын спектрийн судалгааг үндэслэн C₁₆H₁₂O₆ томъёотой бодис болохыг тогтоов.



Зураг 2

Дээрх 2 флавоноидыг урьд өмнө ургамлаас ялгагдаагүй шинэ бодис болохыг тогтоолоо.

Фармакологийн судалгааны үр дүн

Нарийн навчит цахилдагийн усан ханд нь ЭБ-ийн эсрэг явагдах дархлалын урвалын эрчимжилтийг дэлүүний индексийн үзүүлэлтээр 1,22 дахин, гемааглютинины титрийн үзүүлэлтээр 1,43 дахин багасгаж, мэдэгдэхүйц иммунодепрессант үйлдэл үзүүлж байгаа нь ажиглагдлаа. Бэлдмэлийн ийм иммунодепрессант үйлдэл CCl₄ -өөр өдөөгдсөн “дархлал дутагдал”-ын загвар дээр ч нэгэн зэрэг илэрч, дэлүүний эсийн тоог 1,43 дахин, дэлүүний индексийг 1,32 дахин, гемааглютинины титрийг 1,8 дахин бууруулж байв. Сонирхолтой нь Нарийн навчит цахилдагийн бэлдмэлийн иммунодепрессант үйлдэл нь түүний прооксидант идэвхи буюу мембран дахь шиффийн суурийн (ШС) концентрацийг 1,29-1,7 дахин нэмэгдүүлсэн үйлдэлтэй зэрэгцэн нөхцөлдөж явагдаж байсан явдал юм. Өөрөөр хэлбэл уг бэлдмэл нь дэлүүний эсийн мембранд МДА, ШС зэрэг өөхний хэт исэлдэлтийн бүтээгдэхүүний хэмжээг харьцангуй нэмэгдүүлэх замаар эсийн хуваагдлын эрчмийг сулруулах үйлдэл үзүүлдэг байж болох бөгөөд хэт исэлдэлтийн бүтээгдэхүүнүүд нь ДНХ-ийн бүтцийн хэсгүүдтэй холбогдон, бэжжүүлж, түүний репликацийг саатуулан, хавдрын эсийн ургалтын эсрэг үйлдэл үзүүлдгийг судлаачид тогтоосон байдаг(2, 3, 4). Энэ нь бидний өөр нэг судалгаагаар батлагдаж байгаа бөгөөд Нарийн навчит цахилдагт прооксидант

(ПО), антиоксидант (АО) гэсэн харилцан эсрэг үйлдэлтэй биеэ даасан хоёр бодис нэгэн зэрэг тэнцвэртэй баланслагдан агуулагдаж АО үйлдэлтэй фракци нь өөхний хэт исэлдэлтийн процессийн (ӨХИП) эрчмийг хяналтаас 1,5-3 дахин сулруулж байхад ПО үйлдэлтэй фракци нь ӨХИП-ийг хяналтаас нь ПО үйлдэлтэй фракциараа нөхцөлдөн явагддаг байж болох нь харагдлаа.

НОМ ЗҮЙ

1. Г.Пүрэвсүрэн (1995) Нарийн навчит цахилдгийн фитохимийн судалгаа, "Монгол туургатны уламжлалт анагаах ухааны олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. УБ. 49-50х

2. Дмитриев.Л.Ф. (1990) Возможная роль МДА в регуляции клеточного деления, **Молекулярная биология**, № 2, с 566-572

3.Лященко.В.А. (1983) Механизм активации лимфоцитов., М, Медицина, 281 с.

4. Петров.Р.В., Хаитов.Р.М., Атауллаханов.Р.И, (1983) Иммуно-генетика и искусственные антигены, М, Медицина, 256 с.

5. Саранцэцэг.Б, (1994) Цэх галуун таваг ургамлын нийлбэр алкалоидын фармакологийн судалгаа, АУ дэд докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол, 198 с.

6: Хишгээ.Д,(1995) Фитохимическое изучение двух видов горечавковых, применяемых в традиционной медицине Монголии. Автореферат дисс.на соиск.канд.мед.фарм.наук, УБ, 24. с.

7. Шрайнер.Р, (1983) Идентификация органических соединений, М, Мир, 300 с.

НУМРАА ХУНЧИР (*Astragalus adsurgens*.Pall) - ЫН БЭЛДМЭЛИЙН ЗҮРХ СУДАСНЫ СИСТЕМД НӨЛӨӨЛӨХ ҮЙЛДЭЛ

П.Батхуяг Л.Мягмар
Анагаах Ухааны Их Сургууль

Нумраа Хунчир (*Astragalus adsurgens*.Pall) бол Хөвсгөл, Ховд, Монгол Алтай, Дунд халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын нутгаар тархмал ургадаг буурцагтны овгийн олон наст өвслөг ургамал юм.

Түүнийг дорно дахины уламжлалт эмнэлэг тамир тэнхээ сайжруулах зүрхний ажиллагааг тэтгэх, тайвшруулах (1) ба шээс хөөх дэлүү хийгээд ходоод гэдэсний замын эмгэг, төрөлт дэмжих болон эхэсийн гадагшлалтыг сайжруулах (2) чиглэлүүдээр хэрэглэж байжээ.

Нумраа Хунчир нь үндсэндээ азот агуулсан нэгдлүүд, кумарин 1,2 %, флавоноид (3), гамма-амин-тосны хүчил 0,03 % газрын дээд хэсэгтээ сапонин (3) алкалоид 1,2 % (5), Кумарин 0,14-0,17 % (6), флавоноид 3,47 % (7), навчиндаа витамин С агуулдаг болох нь тогтоогдсон юм.

Бид уг ургамлын бэлдмэлүүдийн зүрх судасны системд нөлөөлөх үйлдлийг судлах зорилго тавьсан юм.

Судалгааны арга зүй :

Нумраа Хунчрын газрын дээрх хэсгээс нь хуурай ханд ба хандмал бэлтгэж туршилтанд хэрэглэв.

Бэлдмэлүүдийн цусны даралтанд нөлөөлөх үйлдлийг судлахдаа бэлдмэлүүдийг янз бүрийн тунгаар туулайн хураагуур цусанд тарьж гүрээний артерийн даралтыг нь мөнгөн усны аппараттай холбосон Electro-kybographion M-41 маркийн кимографийн аппаратаар бичлэг хийж, зүрхний бие-цахилгаан идэвхид үзүүлэх нөлөөг нь НЕК-215 маркийн зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар, зүрхний булчингийн агшилтанд үзүүлэх шууд нөлөөг нь туулайн зүрхэнд "insitu" аргаар тус тус явуулав.

Судалгааны үр дүн:

Нумраа Хунчрын хуурай хандын уусмалыг 0,01 г/кг., 0,02 г/кг., 0,04 г/кг тунгаар бодож 4 бүлэг туулайн хураагуур судсанд тарихад артерийн даралтыг 22,41-62,50 %-иар 50-120 минут хүртэл хугацаагаар бууруулж байв.

Үйлдлийн шинж чанарыг тодруулах зорилгоор адреномиметик эмүүдтэй хавсруулан хэрэглэсэн судалгаагаар дээрх бэлдмэлүүд нь адреналин ба мезатоноор үүсгэгдсэн артерийн даралт ихсэлтийг буулгаж байсан ба мөн уг бэлдмэлүүдээр үүсгэгдсэн артерийн даралт бууралтыг адреномиметик эмүүд арилгаж байв. Үүнээс ажиглахад уг ургамлын бэлдмэлүүд артерийн даралтыг бууруулах нөлөөтэй бөгөөд энэ үйлдэл нь адреномиметик эмүүдтэй түүний дотор мезатонтой илүү шууд эсрэг нөлөөтэй байж болох нь харагдлаа.

Хоруу чанарыг тодорхойлох судалгааны үед уг бэлдмэлүүд нь цагаан хулганы чихний судсыг илэрхий өргөсгөж байсан нь тэдний артерийн даралт бууруулах нөлөөтэйг давхар баталж байгаа юм.

Мөн дээрхи бэлдмэлүүдийн зүрхний био-цахилгаан идэвхид үзүүлэх нөлөөг судлах зорилгоор туулайн чихний венийн судсанд 0,02 г/кг-аар бодож тарихад зүрхний цохилтын тоог 6-14-иар цөөрүүлж энэ нөлөө нь 120 минутаас дээш хугацаагаар үргэлжилж байсны дээр ховдол-тосгуурын сэрэл дамжуулалтын хугацааг 14 % хүртэл удаашруулсан.

Харин туулайн зүрхний агшилтанд үзүүлэх нөлөөг "insitu" аргаар туршихад уг бэлдмэлүүд зүрхний булчингийн тонусыг 14,28 %, агшилтын далайцыг 83,33 %-иар бууруулах үйлдэл үзүүлсэн болно.

Дүгнэлт:

1. Нумраа хунчрын бэлдмэлүүд нь артерийн даралтыг бууруулах илэрхий үйлдэлтэй бөгөөд энэ нь адренолитик шинж чанартай байна.

2. Бэлдмэлүүд судлагдсан тундаа зүрхний био-цахилгаан идэвхид сул нөлөөлөх боловч зүрхний цохилтын тоог бага зэрэг цөөрүүлэн ховдол тосгуурын сэрэл дамжуулалтыг удаашруулах хандлагатай байна.

3. Нумраа хунчрын газрын дээд хэсгээс цусны даралт бууруулах нөлөөтэй эм бэлтгэн хэрэглэх бололцоотой байна.

НОМ ЗҮЙ:

1. Шретер.А.И. (1963) Некоторые перспективные в лекарственном отношении растения Дальнего Востока. 225 с.
2. Варлаков.М.Н. (1963) Избранные труды, 425 с.
3. Блинова.К.Ф., Баланкова.Л.Г. (1968) К фитохимическому изучению некоторых представителей рода астрагала. 158 с.
4. Hiki no H., Funayama SH., Endo K. (1976) Hypotensive principle of Astragalus and Hedysarum roots. *Planta med.* v. 18 No 3 p. 158-160.
5. Балдан.Т. (1974) Монгол орны зарим ургамалд алколоидын тодорхойлолт хийсэн дүн, 96 х.
6. Минаева.В.Г., Киселева.А.В., Волхонская.Т.А. (1973) Некоторые результаты обследования растений Красноярского края на содержание флавоновых веществ. *М.Мед.* 219 с.
7. Дунгэрдорж.Д., Петренко.В.В., (1970) Вивчения флавоноидив деяких видов астрагалу поширених, В МНР, 105 с.

Лекц, тойм, зөвлөлгөө

СУДАЛ ШИНЖЛЭЛИЙН ҮНДСЭН БАРИМТЛАЛЫН ТАЛААРХИ МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ОНОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ МӨН ЧАНАРЫГ СУДЛАХ АСУУДАЛД

Ш.Болд, М.Амбага

Монгол улсын ЭМЯ-ны Ардын Эмнэлгийн Хүрээлэн

Судлын улиралчилсан өөрчлөлтийг зөв тогтооно гэдэг нь өргөн утгаараа биемахбодод тогтолцоот байдал зөв үүсч, тухайн улирлын цаг агаар, температур, чийглэг, даралт, "гэрэл-харанхуй" зэрэг хүчин зүйлсийн өвөрмөц нөлөөллийн нөхцөлд тогтолцооны онолоор бол биемахбодын дасал зохицлын ашигтай урвал, МУАУ-ы онолоор бол таван махбод, хий, шар, бадганы тэнцвэржилт гэсэн тогтолцоо үүсгэгч хүчин зүйлийн үр дүн хир зэргийн бүрэн бүтэн хэрэгжилтээ олж байгааг тогтоож багаа явдал гэж үзэж болох юм (3). Дорно дахины анагаах ухааны онолын дагууд бол биемахбодод ийм дасал зохицлын ашигтай урвал (үр дүн) буюу таван махбод, хий, шар, бадганы тэнцвэржилт бүхий байдал тухайлсан нэг улиралд бүрэн төгс бий болохын тулд аль нэг цул эрхтэний үйл ажиллагаа идэвхижиж, түүнтэй дайсны харьцаа үүсгэдэг өөр нэг эрхтний үйл ажиллагаа дарангуйлагдах үзэгдэл тогтолцооны хуулийн дагууд нэг анхдагч элемент ихсэх үед нөгөө анхдагч элементийн хорогдолт зэрэг сэдээгддэгтэй төстэй хэлбэрээр явагддаг гэж үзэх бүрэн үндэс бий (2,3). Ийм зүй тогтолт үзэгдэл улирал бүрд өвөрмөцөөр явагдаж чадаж байгаа эсэхийг судал шинжлэлийн аргаар илрүүлдэг байна(4). Үүнтэй холбоотойгоор нэг цул эрхтэн идэвхижиж, өөр нэг цул эрхтэн дарангуйлагдах үзэгдэл улирал бүрд зохистойгоор сэдээгдэн явагдаж (9) тэр нь цул эрхтний судлын өөрчлөлтийн хэлбэрээр илрэхэд хүний биеийн дотоод орчны ямар бодис, бүтэц, медиатор, рецептор, гормон гол

материаллаг субстанцийн үүрэг гүйцэтгэдэг байж болох вэ? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана(2, 3, 4). Жилийн улирал тус бүрийн өвөрмөц ялгаат байдал гэдэг бол тухай, тухайн улиралд илэрдэг температур, чийглэг, даралт, цахилгаан соронзон талбай, цацрагийн фон гэсэн хүчин зүйлсийн харилцан адилгүй илрэлээр нөхцөлддөг болохоор тэдгээрийн үйлдлийг нарийн мэдэрч, хариу урвал үзүүлэхийн хамт улирал бүрд цул эрхтний хооронд явагдах нөхөр-дайсны харьцаанд зохицуулгын нөлөөллөө үзүүлж чадахгүй тийм бүтэц байдаг ахул дээрхи субстанцийн үүрэг гүйцэтгэдэг болох нь маргаангүй.

Бид харьцуулсан судалгаа явуулсны үндсэндээр гадаад орчны бүх физик хүчин зүйлсийн үйлдлийг хурдан хүлээн авч, хариу урвал үзүүлэн, судасны гилгэр булчингийн агшилт-сулралтанд шууд оролцох чадавхитай шингэн-кристалл бүтэц (5), түүний амьд биемахбод дахь гол хувилбарт хэлбэр болсон мембрант байгууламж ийм үүрэг гүйцэтгэдэг байж болохыг илрүүлсэн юм (2). Бид ийм зүй тогтлыг илрүүлсний үндсэн дээр тухайлсан нэг улиралд дасал зохицлын урвал явагдах нөхцөл бүрдэх буюу тогтолцооны хуулийн дагууд анхдагч элементүүдийн "нэмэгдэлт-хорогдолт-хязгаарлалт"-ын үзэгдэл зэрэгцэн явагдах аль нэг цул эрхтний үйл ажиллагаа-судлын илрэл эрчимжих, нөгөө нэг цул эрхтний үйл ажиллагаа-судлын илрэл дарангуйлагдахад уг улиралд дасал зохицлын хариу урвалын хэлбэрээр харьцангуй нэмэгдсэн мембраны аль нэг төлөв (7, 8) гол хөшүүргийн үүрэг гүйцэтгэдэг буюу нэг улиралд хоёр цул эрхтний үйл ажиллагаа-судлын илрэл харилцан эсрэг байдлаар ихсэлт хийгээд дарангуйлалтанд орох нь тус, тусдаа бие даасан хоёр өөр механизмаар бус харин нэг мөн чанар дээр тулгуурлагдсан хоёр илрэлт үзэгдлийн хэлбэрээр зэрэгцэн нөхцөлдөж явагддаг гэсэн шинэ санаа дэвшүүлж байгаж юм. Тухайлбал хаврын улиралд зуны дулаан улиралд дасан зохицох хариу урвалын хэлбэрээр нийт биемахбодын мембрант байгууламжид бетта хатуу төлөв ихсэх үзэгдэл нь шингэн альфа төлөвт мембраны хэт ихсэлтээс нөхцөлдөн эмгэг үзэгдэлд амархан өртөгдөн нэрвэгдэж болзошгүй чанартай цул эрхтэн болох элэгний эсийн мембранд тэнцвэрт байдлыг бий болгон, уг эрхтний үйл ажиллагаа-судлын илрэл эрчимжихэд хүргэдэг бол ийм механизмаар ихэссэн мембраны хатуу бетта төлөв нь уушигны эсийн мембраны хатуу бетта төлөвийг бетта+бетта механизмаар улам нэмэгдүүлэн сурфактангийн нийлэгжилтийг саатуулж,

адренорецепторын тонусыг сулруулан, холинорецепторын тонусыг нэмэгдүүлэх замаар мөгөөрсөн хоолойн гилгэр булчингийн агшилтыг ихэсгэн, уушгины агааржуулалт, хүчилтөрөгчийн нэвчилт, прооксидант чанартай хүчилтөрөгчийн идэвхитэй хэлбэрийн (ХИХ) үүсэлтийг хориглон, "суларсан" уушги нь "идэвхжисэн" элэгний үйл ажиллагааг улам эрчимжүүлэх нөхцөлийг бий болгон, уушгины макрофаг эсэд үүсдэг ХИХ-ийн зүгээс элэгний эсийн мембраныг гэмтээх үйлчилгээг дарангуйлах саногенезийн үйлдлийг үзүүлэх ба ийм зохицуулга мембраны бетта төлвийн ихсэлтийн хөшүүргээр зөв эрчимтэй явагдаж байгаа ерөнхий хандлагыг элэг-уушгины харилцан эсрэг чанартай судлын илрэлээр тогтоодог гэж үзэж болох юм. Уг хөшүүргийн үйл ажиллагаа цагийн зүүний эргэлтийн дагуу зөв эрэмбээр явагдах тодорхой утгандаа саногенезийн ач холбогдолтой бөгөөд босгон заагийг давж, хэт огцом явагдах үед уушгины үйл ажиллагаа бетта+бетта механизмаар хэт дарангуйлагдаж, эмгэг урвал сэдээгдэхэд хүргэж болох ба энэ үзэгдэл мөн элэгний эсийн мембранд бетта-альфа чиглэлээр хэт сэдээгдвэл түүний үйл ажиллагааг дарангуйлах тааламжгүй нөлөөлөл үзүүлж болзошгүй бөгөөд тэр нь элэгний судлын илрэл дарангуйлагдсан хэлбэрээр гадаад илрэлээ үзүүлдгийг МУАУ-д өвчин өдөөгдөх дохиолол гэж үздэг бөгөөд (9) энэ нь тогтолцооны онолын үүднээс дасал зохицлын ашигтай урвал, уламжлалт анагаах ухааны онолоор таван махбод, хий, шар, бадганы тэнцвэржилт бий болж чадахгүй байна гэсэн үг юм. Эцэст нь хэлэхэд судал шинжлэлийг улирлаас хамааруулан явуулна гэдэг нь угтаа мембраны хөшүүргийн үүрэг тухайнцаг улиралдаа зөв зохицон өөрчлөгдөж, тогтолцооны хуулийн дагуу эрхтэн хоорондын "үйл ажиллагааны ихсэлт-хорогдолт-хязгаарлалтыг" зохицуулан, биемахбодод дасал зохицлын ашигтай үр дүнг гаргах буюу таван махбод, хий, шар, бадганы тэнцвэржилтийг бий болгох, бий болгож байгаа эсэхийг цул, сав эрхтэн бүрд харгалзан тохирсон судлуудын өвөрмөц илрэл, эрчим, бууралтаар тодорхойлж байгаа хэрэг бөгөөд ийм зохицуулгын алдагдал судлаар илрэх үед нийгэм, сэтгэл санаа, амьдралын дэглэм, хоол унд, эм заслалын зөв горимыг баримтлах замаар уг хөшүүргийг зөв зохистой ажиллагаанд оруулах давхар мэдээллийг мөн судал шинжлэлийн арга давхар өгдөг гэж хэлж болох юм. Мембраны хөшүүргийн хоёр талт (нэг эрхтнийг эрчимжүүлэх, нөгөө эрхтнийг сулруулах) үйл

ажиллагааны зохицуулга дээр нийгэм, сэтгэхүй, хоол унд, амьдралын дэг маяг зэрэг өөр хоорондоо ялгаатай полиморф хүчин зүйлүүд ирж, "оролт" хийж, интеграцилагдан, зөвхөн хийг, шарыг, бадганыг ихэсгэх, багасгах, тэнцвэржүүлэх гэсэн хүрээний ижилсэлтэнд орж, ХШБ, таван махбодын тэнцвэржилтийг бий болгосон "гаралт"-ыг үүсгэх, эрүүл оршин тогтнохуйн үндсийг хангаж, тогтолцоот байдал бий болж байгааг судал шинжлэлийн арга харуулах ба мембраны хөшүүргийн үүрэг алдагдаж, тогтолцоот байдал хямралд орж байгааг өвчний судал, халуун-хүйтэн-хийн судал, судлын улиралчилсан илрэлийн эмгэг өөрчлөлт хэмээн томъёолдог байна.

НОМ ЗҮЙ

1. Амбага.М. (1994). Хий, шар, бадганы онол ба мембрант байгууламж. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол, УБ, 301 х.

2. Амбага.М., Саранцэцэг.Б. (1995) Хий, шар, бадгана-мембрант байгууламж, УБ, 78 х.

3. Амбага.М. (1996) "Хий, шар, бадгана-мембрант байгууламж" шинэ санааг тогтолцооны онолын үүднээс тайлбарлах нь, Шинжлэх ухааны академийн мэдээ, № 1 /хэвлэлтэнд/

4. Болд.Ш., Амбага.М., Саранцэцэг.Б. (1995) Судлын улиралчилсан өөрчлөлтийн тухай МУАУ-ы ойлголт ба мембрант байгууламж, "Эрүүл мэндийн салбарын тулгамдсан зорилт", Онол практикийн бага хурлын илтгэлийн хураангуй, УБ, х 24-25

5. Браун.Г., Уолкин.Дж.(1986), Жидкие кристаллы и биологические структуры, Москва, Мир, 256 с.

6. Дагвацэрэн.Б. (1995) Основные теоретико-методические закономерности Монголо-Тибетской традиционной медицины", Автореферат диссертации на соискание уч.степени доктора мед.наук, УБ,

7. Иванов.В.Н., Ахметов.В.Д., Делидов.О.А. (1984) О влиянии трансмеридиального переезда на адаптационную динамику ЖК состава плазмы крови у здоровых людей, Вопросы питания, № 4, с 26-30

8. Крепс.Е.М., (1981) Липиды клеточных мембран, Л, Наука, 340 с.

9. Пуйпышев.В.Н. (1991) Тибетская медицина, Новосибирск, 141 с.

ХИЙ, ШАР, БАДГАНЫ МӨН ЧАНАР БА БИЕМАХБОДИД ХЭРЭГЖИХ ТҮГЭЭМЭЛ ЗҮЙ ТОГТЛУУД

Б.Дагвацэрэн
Ардын эмнэлгийн хүрээлэн

Аюурвед, Төвд, Монголын уламжлалт анагаах ухаан (УАУ)-ы онол аргагүйн үндэслэл болсон язгуурын 5 махбод тэдгээрээс уламжлан гаргасан хий, шар, бадганы мөн чанар юу байж болох? юу байж болохгүй вэ? яагаад ийм ойлголт гарах болов? гэх мэтийн асуултууд УАУ-ы хөгжлийн явцын туршид судлаачдын өмнө тавигдсаар ирсэн боловч өнөөг хүртэл зохих ёсоор шийдвэрлэгдсэн нь үгүй билээ.

Бид энэ удаа "алимад тогтолцоонд юу байж болох, юу байж болохгүйг тодруулах боломж олгодог тогтолцооны ерөнхий онол (ТЕО)", түүнчлэн синергетик хандлагыг аргагүйн үүднээс дээрхи асуултуудад үндэслэлтэй хариулт олох зорилт тавьж ажилласан зарим дүнг авч үзлээ.

Хий, шар, бадганы тухай УАУ-ын үзэл баримтлал, үндсэн ойлголтыг хураангуйлан дүгнэвэл: А.Огторгуй, Хий, Гал, Ус, Шороо зэрэг язгуурын таван махбодиос хий, шар, бадганыг хураангуйлан гаргаж ирэхийн хамт, тэдгээрийг зөвхөн амьд биемаходын тогтолцоог шинжлэн үзэхэд л ашигладаг, Б."Энэхүү хий, шар, бадгана гуравын шалтгаан бол тачаангуй, урин, мунхаг гурав дараалан болох ёстой. Мөн чанар нь тэгш, халуун, сэрүүн гурав магад болох, үр нь хий, шар, бадгана гурван гэмийг магад үүсгэнэ. Ерөндөгийн магад тоо бол шороо, ус, гал ийм гурав буй... Эсвэл хүнд, сэрүүн, хөнгөн гурав байж дүр урвасан үрийг дараачлан дарна". (2) гэж бичсэнээс үзвэл хий, шар, бадгана нь сэтгэл санааны болон материаллаг хүчин зүйлсийн алиных нь ч нөлөөлөлд орох, орших, өөрчлөгдөх боломжтой, хоорондоо арга-билгийн харьцаатай байх: В.Хий, шар, бадгана нь биед ихэвчлэн байрших оронтой, гол төлөв хөдлөх буюу идэвхжих цаг хугацааны үелэлтэй, давамгайлан гүйцэтгэх үйлтэй болдог учраас дотор зуураа ялгагддаг, ялгаатайн эрхээр тус бүрдээ тодорхойлогдох билэг чанараар томъёологддог байна.

Эдгээрийг иш үндэс болговоос хий, шар, бадгана нь алимад юмс үзэгдлийн түгээмэл эхлэл гэх язгуурын 5 махбодиос

(логикийн хувьд анхдагч аксиом гэж үзэх) хийсвэрлэн (аксиоматик аргаар гэж болох) гаргасан, амьд биемахбодын бүхий л хэсэгт оршин, үйл ажиллагаанд нь зохицуулах үүрэгтэй оролцох боломжтой, өөрсдийн билэг чанараараа л тодорхойлогддог, биемахбод-тогтолцооны түгээмэл цомхотгомол чанарыг томъёолсон (логик аксиом буюу перидикат) ухагдахуун болж ирдэг (6) Энэ нь үндсэндээ орчин үеийн ТЕО-оос урган гарч ирдэг тогтолцооны "анхдагч элемент" гэсэн ойлголттой зарчмын хувьд төстэй болдог буюу түүнд тавигдах үндсэн гол шинжүүдийг өөртөө агуулж байгаа нь харагддаг.

ТЕО-ын хамгийн бодит хувилбарыг боловсруулсан гэгдэх Ю.А.Урманцев (4) тогтолцооны "анхдагч элемент"-ийг тодорхойлохдоо: "ТЕО-ыг боловсруулахад үндэслэл болгосон 5 аксиоматик нөхцлийн нэг болох "нэгдмэл (единое) нь логикийн үүднээс ангилалын суурь болохуйц, тухайн тогтолцооны (тухайн төрлийн объектын тогтолцоонуудын) бүхий л зохиомжинд адилхан байх ЧАНАР буюу ШИНЖ юм. Цаашдаа тийм шинж тэмдгүүдийг бид A_t шинж тэмдгүүд гэж нэрлэнэ.

Тухайн i -дугаар тогтолцоог, объектуудаас A_i сууриар ялгасан зөвхөн (M_i) олонлогоор буюу анхдагч элементүүдийн олонлогоор байгуулах учир нөхцөл "нэгдмэл"-ийг харгалзах шаардлага гарч ирдэг" гэж бичжээ. Эндээс үзвэл тогтолцооны "анхдагч" элементүүдэд: а.логик аксиоматик аргаар гарган авч болох: б.тогтолцооны бүхий л байгууламжинд адилхан хадгалагдах чанарыг төлөөлж чадах: в.тогтолцоо орших гол шинж-нэгдмэлийг нөхцөлдүүлэгч байх зэрэг шаардлагууд тавигддаг байна.

Тэгвэл хий, шар, бадгана нь язгуурын гэх анхдагч 5 махбодиос бясалгалын болон логик аргаар хийсвэрлэн гаргаж ирсэн, биемахбод-тогтолцооны бүхий л бүтцэд оршиж чадах "билэг чанаруудын цогц" бөгөөд биемахбод-тогтолцооны бүхэл нэгдмэл байхыг нөхцөлдүүлэгч буюу "бие бүтэх, орших, эвдрэхийн" "Дөрвөн үндэс" болдогоос алимад объект-тогтолцооны "анхдагч элементүүдэд" тавигдах үндсэн шаардлагуудыг хангаж байдаг нь харагддаг.

Язгуурын 5 махбодын мөн чанарыг буддист Г.Лувсанцэрэн (7) "өөрийн дотоодод шингээмэл буй төрөлхи билэг чанар, үйл үйлдлийнхээ хүчээр, ахуй сэтгэлийн бүх юм үзэгдлийг цогцлон бүтээх хумхийн тоосноос үүдэлтэй... анхдагч язгуурууд буюу махбод нь мэдрэгдэн хүртэгдэгч шороо, ус, гал, хий дөрөв биш

юм. Гагцхүү хүнд, нойтон, дулаан, хөнгөн хэмээх анхдагч дөрвөн чанарыг ертөнцийн нэр нийтгэлд гадаад өнгө, дүрийг нь баримтлан шороо, ус, гал, хий гэх зэргээр томъёолон нэрийддэг, үүнийг нь дагаж, тэдгээр чанарыг хүмүүст ухааруулан буулгахын тулд л шороо, ус, гал, хий гэж дараалуулан оноож нэрлэсэн ажээ. Угтаа ертөнцийг үүсгэн бүтээх эхлэлүүд нь хүнд, хөнгөн зэрэг анхдагч дөрвөн билэг чанар болоод хураах, хөдлөх зэрэг үйл үйлчлэл бүхий материаллаг элементүүд л байх юм. Эдгээр эхлэлийг, элементийг **вайбхашика** философчид “маш нарийн тоос (**paramana**) мөн гэж үздэг болно” гэж ойлгожтойгоор тайлбарлажээ.

Эндээс үзсэн ч махбод нь логик сэтгэлгээ, бясалгалын аргаар таньж мэдсэн, ертөнцийн анхдагч чанарын билэгдэл, аксиоматик томъёолбор, анхдагч перидикат, ТЕО-оор бол “бичил ба үлэмж ертөнц-тогтолцооны” анхдагч элементүүдийн байж болох олонлог болж ирдэг. Харин хий, шар, бадган бол энэхүү анхдагч перидикатыг (аксиомыг) үндэслэн амьд биетийн өвөрмөц байдалд зохицуулан гаргаж ирсэн “хоёрдогч перидикат” (таван махбодын хувь шүү), амьд биемахбодын хувьд бүтэц-үйлийн нэгдлийн анхдагч цомхотгол түгээмэл чанарыг л томъёолсон илэрхийлэл, ТЕО-ын үүднээс бол “биемахбод-тогтолцооны” “анхдагч элемент” болдог гэсэн шинэ санааг дэвшүүлэх бололцоо олдож байгаа юм.

Эртний дорнодахины сэтгэгчид бясалгал ба логик танин мэдэхүйн хийсвэрлэх аргаар л ертөнцийн юмс үзэгдлийн бүхэл, нэгдмэл байдалд хэрэгжих зүй тогтолыг таньж мэдэхдээ тэдгээрийг эхлээд “тусгайд” задлан бүр хамгийн эцсийн нийтлэг элемент болох хийсвэрлэн гаргаж авсан чанарт хүрч түүнийгээ л “ертөнц-тогтолцооны” хувьд 5 махбод, “биообъект-тогтолцооны” хувьд бол хий, шар, бадган хэмээн томъёолон нэрийдсэн хэрэг болж байгаа юм.

Их сэтгэгч Нагаржуна “Хоосон чанарын далан шүлэг” зохиолдоо “Төрөх, эвдрэх, орших ба буй үгүй доорд ба сацуу ба ялангуяатыг Бурхан Будда ертөнцийн томъёоны эрхээр номлосон буй за, үнэхээрийн эрхээр бус” гэсэн нь үнэндээ тухайн юмс үзэгдлийн хоорондын харьцааны ялгаварт заагийг илэрхийлэхийн тулд л ойлголт түүнийг тэмдэглэсэн томъёолол гарч ирдэг гэж хэлсэн бололтой.

Өнөөдөр “биообъект-тогтолцооны анхдагч түгээмэл чанар” буюу “анхдагч элементийг таньж мэдэх, олж тогтоох гэсэн

оролдлого эрчимтэй хийгдэх боллоо гэж үзэж байна.

Шинжлэх ухааны цэгцтэй онол боловсруулахад тухайн тогтолцооны "Систем үүсгэгч хүчин зүйл" (систем образующий фактор) (3) "түгээмэл цомхотгол чанар" "анхдагч чанар-загвар" (свойства-образец) -ыг үндэслэлтэй шийдвэрлэх, эсвэл "хийсвэрлэсэн өгөш объект" (логический затравочный объект), "өгөш-ойлголт" (затравочное понятие) тавьж өгөх (10) шаардлага зайлшгүй болж гарч ирдэг.

"Анхдагч элементийн " эрэл хайгуул эцэстээ эртний дорнодахинд бясалгал, логик аргаар таньж хүртсэн 5 махбод ба хий, шар, бадганы ойлголтыг "дахин нээхэд" хүргэх юм биш үү!?

Хий, шар, бадганы номлолыг ТЕО онол ба Синетгетик хандлагын аргазүйн үүднээс шинжлэж үзэхэд тэдгээр нь өнөөдрийн шинжлэх ухааны таньж мэдсэн түгээмэл чанартай мэдээлэл, энерги, материаллаг мэтийн хийсвэр ойлголтыг өөртөө нэгтгэн агуулж чадахын хамт биотогтолцооны дотоод дахь бүтцүүдийн шүтэн барилдсан харьцаа хамааралт үйлдэлд л илэрч байдаг " түгээмэл мөртлөө анхдагч чанар" мөн болох нь улам тодорхой болж байгаа юм.

Биотогтолцооны энэхүү "анхдагч түгээмэл шинжтэй чанар"-ын (хий, шар, бадганы) хэвийн хөдлөнгө тэнцвэрт харьцаат байдал өчүүхэн хэмжээнд өөрчлөгдөхөд л (дүр нь урвабал) тэр нь нийт биемахбодын нэгдмэл харьцаанд илэрдгийг "хямрал, өвчин" гэж үздэг УАУ-ы ойлголт ойлгомжтой болдогийн хамт ерөөсөө хий, шар, бадганыг "гэм", "хорлогч" хэмээн нэрийдсэний учир ч тодорхой болдог.

Ийнхүү хий, шар, бадганы мөн чанар, учир холбогдлыг өчүүхэн бээр ухаарахын хирээр бид өнөөдөр эрчимтэй хөгжиж буй ТЕО-ын хүрээнд нэгэнт тогтсон "томъёо лын эрхшээлийг дагаж, тэдгээр нь "биообъект-тогтолцооны" анхдагч элементтэй" утга нэгэн буюу ойролцоо байна гэсэн зарчмын дүгнэлт хийхэд хүрсэн юм.

УАУ-ы хий, шар, бадган нь биемахбод-тогтолцооны "анхдагч элементтэй" утга агуулгын хувьд төстэй ойлголт гэж үзэхдээ бид "энерги-материаллаг-мэдээллийн" аль алинаас нь чанагш орших бөгөөд тэдгээрт нийтлэг шинж байдаг бол түүнийг л тусгасан "анхдагч түгээмэл ЧАНАР"-аар ойлгож буйгаа цохон тэмдэглэе.

"Анхдагч" буюу хэсгийг таньж мэдвэл түүгээр дамжин бүхэлд

хэрэгжих зүй тогтолыг таньж мэдэж болно гэж Гегель сургасан байдаг. Үнэндээ "биобъект-тогтолцооны анхдагч элемент" гэж бидний үзсэн хий, шар, бадганы номлолд дулдуйдах замаар УАУ-ы онол аргагүйн гол үзэл баримтлал, үндсэн ухагдахуун, ойлголтуудыг цогцлон бүтээсэн байдаг нь ойлгомжтой болохын хирээр өөрөөр байж болохгүйн учир нь анзаарагддаг билээ. Энэ үзэл баримтлалыг орчин үеийн ТЕО ба Синергетик чиглэлийн хандлагын үүднээс задлан шинжлэж үзвэл анагаах-биологийн ухааны хувьд бүрэн таньж мэдэгдээгүй байсан гэж болох доорхи зүй тогтлууд хэрэгжиж байдаг нь мэдэгдсэн юм.

1. "Онолын үндэс"-д "Биеийн билэг чанарт: хорлогдох махбод хийгээд хорлогч гэж 2 зүйл бий болой. Өвчин (гэм), биеийн тамир, хир 3 нь хоорондоо харилцан шүтэлцэх харьцаатай байж тогтох, орших, эвдрэхийн үндэс болдог тул энэ гурвыг хамтатган бие гэдэг" гэж бичсэн байдаг нь үнэндээ биемахбод-тогтоцооны анхан шатны загварын тодорхойлолт юм гэж ойлгодог.

"Биемахбод-тогтолцооны" уламжлалт энэ загварыг тогтолцооны нийтлэг шинжийн үүднээс задлаж үзэхэд, түүнд: тогтолцоог бүрдүүлэгч элементүүдийн олонлог: чанар: харьцаа: шатлал: байгуулалт: гадаад орчинтойгоо шүтэлцэх харьцаа: зорилго зэрэг гол шинжүүд хадгалагдаж байгаа нь тогтоогдсон билээ. (6) Харин биемахбод-тогтолцооны анхан шатны энэ загвар нь, биемахбодын "анхдагч түгээмэл чанар болох хий, шар, бадганыг" тусгасан учраас орчин үеийн биоанагаах загваруудаас зарчмын ялгаатай болж ирдэг.

2. УАУ-д хүний авир төрх, биеийн галбирын өөрчлөлт (конституция): түүнчлэн биеийн ерөнхий өвчнүүдийн үндсэн билэг чанаруудыг тооцон тогтоохдоо бие-тогтолцооны "анхдагч элемент" болох хий, шар, бадганы байж болох зохиомжийг

үндэслэн 7-гоор $\left(\sum_{i=1}^3 C_3^i = 7 \right)$ тоолсон байдаг нь ТЕО-

ын "объект-тогтолцоог" хувиргах 1 түгээмэл хуулиар хэрэгждэг болох нь тодорхой болсон.

3. Түүнчлэн хий, шар, бадганы билэг чанарын өөрчлөлтийг (арвидах, хасагдах ба буруудах): бас гаднын хүчин зүйлсийн шүтэлцэх барилдлагын ерөнхий хувилбар (хэтрэх, дутагдах, буруудах)-ыг 3-т тус тус хураасан байдаг нь ТЕО-ын "объект-

тогтолцоог” хувиргах II түгээмэл хуулиар (+;-;+;-) (тус тус хэрэгждэг болох нь тогтоогдсон) (7,9).

4. УАУ-ы “бүхэнд түгэх ерөнхий өвчнийг эрхэмийн үүднээс ялгасан (ангилсан) байдал нь тогтолцооны ижил хэлбэршил (закон изоморфизация) үүсэх тухай ТЕО-ын хувиргалтын III түгээмэл хуулинд үндэслэгдсэн болох нь судалгааны явцад мөн тодорхой болсон билээ. Тогтолцооны зохиомжийг хувиргах III хуулиар бол хэрэв Si тогтолцоон дахь объект-тогтолцоонуудын “анхдагч элементүүдийн хоорондын зарим харьцааг нөгөөд хувирган хоёр ба түүнээс олон объект-тогтолцоонд шилжүүлэхэд тэнд ижэлхэлбэршил буй болж байдаг. (13) УАУ-д “бүхэнд түгэх ерөнхий 101 өвчнийг “ангилахдаа “бие-тогтолцооны анхдагч элемент” болох хий, шар, бадганы өөр хоорондоо болон дотор зуурын зөвхөн харьцааны өөрчлөлтийн байж болох хувиралтыг тооцох замаар хийсэн байдаг (5,8)

Биеийн ерөнхий өвчний уламжлалт энэ ангилалд аливаа байгалийн чанартай өөрөө эрэмблэгдэх /самоорганизация/ тогтолцооны дотоод бүтцийн харьцааны өөрчлөлтөд илэрдэг түгээмэл зүй тогтол ажиглагдаж байгаагийн өөр жишээнүүд гэвэл түүнд шинж тэмдэг удамших тухай Менделийн I, II, III хуулиуд ба тэгшхэмийн хувиргалтын түгээмэл зарчим хадгалагдаж буй явдлыг дурьдаж болно.

5. УАУ-ы эмийг амтаар ба амтын чадлаар найруулах үндсэн арга нь ТЕО-ын тогтолцооны зохиомжийг хувиргах IV түгээмэл хуулинд үндэслэгддэг болох нь мөн тогтоогдсон билээ. Олон хэлбэршилийн (закон полиморфизация) энэ хуулиар бол “объект-тогтолцооны” “анхдагч элементүүдийн” хоорондын харьцаа ба тоог бүгдийг эсвэл хэсгийг нь өөрчлөн тэр нэг л төрлийн объектуудын тогтолцооны хүрээнд шилжүүлэхэд тогтолцоонд олон хэлбэршил үүсдэг билээ.

Уламжлалт аргаар эм найруулна гэдэг нь янз бүрийн амт, чадалтай эмт бодисыг тодорхой харьцаа, хэмжээгээр (тоо) хольж хүссэн амт, чадалтай эм гаргаж авна гэсэн хэрэг билээ. Энэ үед “найруулсан эм-тогтолцооны” “анхдагч элементүүд” болох амт, чадлын тооны болон харьцааны хувиргалтыг зэрэг хийж байгаа нь тодорхой учир түүнд тогтолцоог хувиргах олон хэлбэршлийн хууль хэрэгжхэд хүрдэг байна. УАУ-д 6 үндсэн амт байдаг гэж үзээд тэдгээрийн зохиомжийг 63-аар тоолсон байдаг нь “бүхэнд түгэх ерөнхий өвчний” тоотой нарийн дүйцэж ирдэг билээ (5)

ТЕО-ын үүднээс авч үзвэл ижилхэлбэршил ба олонхэлбэршил нь хоорондоо эсрэг тэсрэг нэгдэл тэмцлийн буюу өргөн утгаараа арга билгийн харьцаа хамааралд оршиж байдаг. Тэгвэл УАУ-ы ойлголтоор хий, шар, бадганы 20 билэг чанар нь “бие-тогтолцоог” төлөөлдөг бөгөөд түүнд харгалзах, эмийн 8 чадал буюу 17 эрдмийн зохицуулага нь “идээ ундаа, явдал мөр, эм, засалд” хураангуйлсан гадаад орчны бүхий л хүчин зүйлсийн нөлөөллийг өөртөө агуулахад хүрдэг.

6. Ийм учраас өөр хоорондоо арга-билгийн харьцаатай “бие-тогтолцоо” (г) \leq “эм-тогтолцоо” (э) гэсэн хамаарал гарч ирдэг. Үүнийг $\Xi=f(r)$ гэж томъёолж болох юм. Тнэ хамаарал УАУ-ы онол аргазүйн голд тавигддаг буюу биемаход орчинтойгоо шүтэн барилдаж орших ёсыг тодорхойлдог гэж үзэхэд хүргэсэн билээ (7,9)

7. Уг харьцааны биемахбод эрүүл байх үеийг тодорхойлогч инвариант утгыг тооцож үзэхэд, Фибоначчийн S-огтлолтой тесеетэй 0,509; 0,618; 0,627; 0,666; 0,717; 0,737; 0,839; 0,928; 0,948; 1 гэсэн цуваа тоо гарч байсан.Энэ цуваа тоо алимад тогтолцооны зохиорлтой (гармоничный) шинжийг илтгэх математик алтан огтлолын 0,618...-тай холбоотой байв.

Бид уг цуваа тоог УАУ-ы 3о-огтлол (зо-Зохирол) гэж нэрлэсэн.Эндээс үзвэл УАУ-ы онол аргазүй зохиорлын түгээмэл зүй тогтолд үндэслэгдсэн байна. УАУ-ы 3о-огтлолын цуваа тоо нь бие эрүүл орших үеийн хий, шар, бадганы хөдлөнгө тогтворт байдлыг зааж өгдөг.

8. УАУ-ы бие-тогтолцооны “3 гэм-7 тамир-3 хир” загварын бүтцүүд болон 5 цул,6 сав эрхтнүүдийн гүйцэд хэмжээний (битүүгээр илэрхийлсэн) хоорондын хамаарлыг, тоог хуваах загварын аргаар шинжлэхэд , алимад тогтолцооны төгс төгөлдөрийг илтгэх -0,500; 0,571; 0,600; 0,625; 0,666; 0,750; 0,714; 0,777; 0,800; 0,833; 0,857; 0,875; 0,888; 1 гэсэн цуваа тоогоор тодорхойлогддог нь мэдэгдсэн. УАУ төгс төгөлдөрийн түгээмэл зүй тогтолд үндэслэгдсэн байна (6).

Монгол, Төвдийн УАУ-ы онол аргазүйн үзэл баримтлалд илэрсэн эдгээр түгээмэл зүй тогтолуудаар, биемахбод гадаад орчинтойгоо шүтэн барилдах ёс тодорхойлогддог байна.

Анагаах ухаанд өмнө нь мэдэгдээгүй байсан энэхүү түгээмэл зүй тогтолд үндэслэн “анагаах ухааны цомтгомол нэгдмэл онол аргазүй” боловсруулах бололцоо гарч ирсэн юм. Бид дэвшүүлж

буй энэ онол аргагүйгээ үндэслэн УАУ-ы цөөн ба олон найрлагатай эм, тангийн жорын найрлагыг задлан шинжлэх замаар "бүлэглэн шаталж эм найруулах шинэ зарчим", уламжлалт эмнэлгийн эм, эмийн зүйлсийн "гэмд" нөлөөлөх амтын чадлын үйлдлийн Жишиг итгэлцүүрийг тооцох 2 аргыг боловсруулсан болно (9).

НОМ ЗҮЙ:

1. Ютиг Ёндонгомбо, (1959) IX-X зуун. Анагаах ухааны дөрвөн үндэс. дээд дэвтэр, Хөх хот, 178 х.
2. Дармаамаарамба Лувсанчойдог, (1984) XVI зуун. Алтан хадмал, Хөх хот, дээд дэвтэр х 388-416
3. П.К.Анохин (1974) Общая теория функциональных систем организма. В кн: Прогресс биологической и медицинской кибернетики., М. "Медицина", с. 125-128.
4. Гегель., (1974) Наука логики., М, "Мысль", 1974, с 452
5. Б.Дагвацэрэн (1993) Уламжлалт эм найруулах онол аргазүйн үндэслэл. ШУА-ийн мэдээ. № 2. х.30-36.
6. Б.Дагвацэрэн (1994) Уламжлалт анагаах ухааны тогтолцооны төгс чанар. ШУА-ийн мэдээ. № 3-4. х. 64-71.
7. Б.Дагвацэрэн (1994) Зохиролт тогтолцоо. МАУ. №4. х.3-9.
8. Б.Дагвацэрэн. (1995), Анагаах биологийн төгс зохиролт цомтгон нэгтгэсэн онол, аргазүйн үндэслэл. ШУА-ийн мэдээ. № 1, х 16-20.
9. Б.Дагвацэрэн. (1995) Основные теоретико-методологические закономерности Монголо-Тибетской традиционной медицины. Автореферат сойск. уч. ст. доктора медицины. УБ, 21 с.
10. С.Н.Жаров (1990) Затравочные абстрактные объекты как системобразующий фактор становления научной теории. В кн: Естествознание, системность и динамика. М. "Наука" 33 с.
11. Г.Лувсанцэрэнн. (1987) Буддын философийн түүхээс. УБ "ШУА-ийн хэвлэл", х.42-43.
12. Г.А.Смирнов (1991). Элементаризм, целостность и проблема универсалии. В кн: Системные исследования, Ежегодник: 1987-1990. М. Наука", 142 с.
13. Ю.А.Урманцев (1988) Система, Симметрия, гармония., М, "Мысль", 39 с.

“ХИЙ, ШАР, БАДГАН-МЕМБРАНТ БАЙГУУЛАМЖ” ШИНЭ САНААНЫ ГҮН УХААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

М.Амбага, Б.Саранц ц г
Ардын Эмнэлгийн Хүрээлэн

Дорно дахины анагаах ухааны судар, номонд (3) тааралддаг гал, ус, шороо, хий, огторгуй таван махбод, халуун, хүйтэн, хүнд, хөнгөн билэг чанар, хий, шар, бадган зэрэг илэрхийллийн дотроос аль нь ажиглан судлагч хүний мэдэрч, тулж танин мэдэхүйгээр илрэн бий болсон, аль нь сэтгэж танин мэдэхүйн хүрээнд үүссэн зүйлүүд вэ? Ямар бодитой материаллаг, субстанцлаг зүйл хүний санаа зоргоос үл хамааран, далдлаг оршихдоо ийм гадаад шинж чанаруудыг нөхцөлдүүлэн, хийсвэрлэгдэж томъёологдохдоо ойлголт, ухагдахуун гарахад хүргэсэн бэ? гэсэн зарчмын чухал асуудлууд тавигддаг (2, 4)

Гэтэл гадаад, дотоодын зарим судлаачдын дунд эдгээр өөр хоорондоо ялгаатай зүйлүүдийг адилтган ижилсүүлж үзэх юм уу?, эсвэл тэдгээрийг хооронд нь хэт салган тасалж, бие биеэсээ хамаарсан нэгдмэл байдлыг нь алдагдуулан тайлбарлаж, хий, шар, бадган (ХШБ), таван махбодын онол, билэг чанар, гадаад олон шинж чанарыг нөхцөлдүүлсэн бодит материаллаг зүйлийг судлан тогтоох ажлын ач холбогдлыг бууруулан, “субстанцлаг, материаллаг зүйл-билэг чанар ухагдахуун” гэсэн танин мэдэхүйн шатлалын дагууд гарч ирдэг нэг гол хүчин зүйлийн талаархи судалгааг орхигдуулах хандлага илэрч байна.

Угтаа бол хүн төрөлхтөн олон арван үзэгдэл юмс дээр ажиглалт хийх явцдаа тэдгээрт халуун, хурц, хүйтэн, мохдог, нойтон, хуурай, хүнд, хөнгөн зэрэг гадаад шинж чанар байгааг мэдэрч танин мэдрэхүйгээрээ илрүүлэн, түүнээсээ хөөж халуун, хурцын цаана гал, нойтон, хүйтний цаана ус, хүнд, мохдогийн цаана шороо, хөнгөн хөлбөрөнхийн цаана хийтэй төстэй гэж хэлж болохуйц шинж чанарыг үүсгэдэг материаллаг субстанци байна гэсэн оюуны дүгнэлтэнд хүрч, гал, ус, шороо, хий, огторгуй, махбод гэсэн хийсвэр томъёоллыг гаргажээ.

Энэ дагуу авч үзэх юм бол гал хэмээн томъёолдог анхдагч

махбодийн үүсгэдэг халуун, хурц зэрэг шинж чанаруудтай адил шинж чанарыг хүний биед үүсгэх чадавхитай субстанцийн оролцоотойгоор явагдах эрүүл, эмгэг бүх үзэгдлийг "шар" хэмээх хийсвэр ухагдахууны дор ус, шороо гэж илэрхийлдэг анхдагч махбодын үүсгэдэг хүнд, хүйтэн, мохдог шинж чанаруудтай адил шинж чанарыг үүсгэдэг субстанцийн оролцоотойгоор бий болдог эрүүл, эмгэг бүх үзэгдлийг "бадган" хэмээх хийсвэр ухагдахуун дор, хий хэмээн томъёолдог анхдагч махбодийн үүсгэдэг хөнгөн, хөлбөрөнхий шинж чанаруудтай адил шинж чанарыг үүсгэдэг субстанцийн оролцоотойгоор явагддаг эрүүл, эмгэг бүх үзэгдлийг" хий хэмээх хийсвэр ухагдахууны дор базан, нэгтгэн илэрхийлжээ гэж үзэж болох юм.

Эндээс хөөн бодож үзэх юм бол хүн, амьтны биед хий, шар, бадган гэсэн хийсвэр ухагдахууны дотоод мөн чанар болсон гурван том субстанцид хамаарагдах харилцан эсрэг, харилцан уялдаат, харилцан шилжимтгий чанартай хэсгүүд оршин тогтнож байна гэсэн төсөөлөл аяндаа гарч ирэх ба тэдгээрийн онцлог нь:

а/ Энэ гурван субстанцийн оролцоогүйгээр үүсдэг эрүүл бүтэц, үйл ажиллагаа, зохицуулга гэж үгүй

б/ Энэ гурван субстанцид нөлөөлдөггүй гадаад, дотоод хүчин зүйлс, эм засал, идээ ундаа, цаг улирал, нас, хүйс, овор төрх, амьдралын дэг маяг гэж үгүй.

в/ Хүний биед үнэхээр ийм гурван субстанци гэж хэлж болохуйц материаллаг зүйл оршин тогтнож, гадаад орчны мэдээллийг хүлээн авч, хариу урвал, энерги бодисын солилцоо гүйцэтгэн, биеийн өсөлт үржилтийг хангаж, өвчний үед өөрчлөгдөн эм засал, эмчилгээний дор эргэн сэргээгдэж, хэвийн болж байгаагийн гадаад илрэлийг "билиг чанар" гэсэн ойлголтоор харуулдаг гэж үзэж болох талтай.

Бид харьцуулсан судалгаа явуулсны үндсэн дээр нэг талаас гал, ус, шороо, хий зэрэг махбодоор хийсвэрлэгдэн томъёологдсон субстанцийн бий болгодог халуун, хүйтэн, хүнд, хөнгөн, хөлбөрөнхий зэрэг шинж чанарыг хүний биед үүсгэх чадавхитай, нөгөө талаас ХШБ гэсэн гурвалсан ухагдахуунаар хийсвэрлэгдэн томъёологдохдоо амьд, амьгүй байгалийн ялгааг харуулж чадахуйц бүтэц бол биемахбодын мембрант байгууламж, түүний гурван төлөв болох тухай дүгнэлтэнд хүрсэн юм(1, 2).

Өөрөөр хэлбэл халуун, хүйтэн, хөнгөн, хүнд, нойтон, хуурай

зэрэг билэг чанар, гадаад шинж чанарууд нь мэдэрч танин мэдэхүйн хүрээнд илрэн илэрхийлэгдсэн, таван махбод, хий, шар, бадганы холбогдолтой илэрхийлүүд нь мэдэрч, хүртэж танин мэдсэн зүйлээ сэтгэлгээний өвөрмөц объектод хувиргах замаар бий болгосон онол, ухагдахууны чанартай зүйлүүд бөгөөд эдгээр онол, ухагдахуун, гадаад шинж чанаруудыг нөхцөлдүүлдэг гол материаллаг, бодит зүйл нь биемахбодын мембрант байгууламж, түүний гурван төлөв болохыг илрүүлсэн юм (1, 2)

Хий, шар, бадганы онол, таван махбодын онолыг нөхцөлдүүлсэн гол бодитой материаллаг, субстанцлаг зүйлийн талаархи "хий, шар, бадган-мембрант байгууламж" шинэ санааг урьд өмнө бичин, илэрхийлж байснаасаа (1) арай өөрөөр баяжуулан үзүүлбэл:

Нэгдүгээрт: Зүрх, тархи, булчин мэдрэл, дотоод шүүрлийн булчирхай зэрэг сэрэмтгий эд, эсийн мембрант багууламжид (МБ) шингэн-кристалл чанартай дундач гамма төлөв давамгайлах үед үйлийн потенциал үүсэлтэнд оролцдог бүх төрлийн уураг, фермент рецептор, гормон, медиатор, ион, ионы сувгийн хэсгүүд нь МБ-ийн уг төлвийн хүрээнд өөр хоорондоо харилцан үйлчлэлцэж, нэгэн хэлбэршилт байдлыг нэг зэрэг үзүүлэх боломжоор хангагдсаны үр дүнд сэрлийн процесс эсийн бичил түвшинд сэдээгдсэний илрэл нь хүний биеийн гадна талд сэрэмтгий, хөдлөнги, хөнгөн, шилжимтгий зэрэг шинж чанаруудаар илэрдгийг МУАУ-д хий хэмээх хийсвэр махбодын хөнгөн, хөлбөрөнхий шинж чанаруудтай адилтган, "лүн" хэмээх ойлголт, ухагдахуун, нэршлийн дор базан илэрхийлжээ гэж хэлж болох юм (2). Мембраны гамма дундач төлвөөр заавал дамжин дээрхи зохицуулгын бүх хүчин зүйлсийн оролцоотойгоор илэрдэг үйлийн потенциалын сэдээгдэлт, деполаризаци-реполаризацийн үзэгдэл алдагдаж, сэрэл үүсэлт, дамжуулалт хэт идэвхижих юм уу, хэт дарангуйлагдах нь хий өвчин, түүний арвидалт, хорогдолтын тухай МУАУ-ы онолтой нийцнэ. (3)

Хоёрдугаарт: Бүх эд, эс, ялангуяа дулааны энерги нийлэгжүүлэх чадавхитай эсэд мембраны шингэн альфа төлвийн харьцангуй давамгайлал сэдээгдэх үед бодис энергийн солилцоо, дулаан үүсэлтэнд оролцдог бүх төрлийн биологийн идэвхит бодис, фермент, гормон, рецептор, медиаторууд нь уг төлвийн зохицуулгын дор харилцан үйлчлэлцэлд орж, интеграцилагдан, нэг хэлбэршилт, нэг чиглэлт, тогтолцоот

үйл ажиллагааг нэг зэрэг гүйцэтгэх боломжийг эсийн бичил түвшинд бий болгосноор дулаан үүсэлтийг хурдасган, сэрлийн процессийн өдөөгдөлтийг эрчимжүүлж, эрүүл, эмгэг хүчин зүйлсийн үйлдлийг мэдрэх чадварыг дээшлүүлсний гадаад шинж чанарууд нь биеийн халуун нэмэгдэх, үйл ажиллагааны эрчим ихэссэн байдлаар тусгагддагийг дорно дахины гүн ухаантнууд мэдэрч танин мэдэхүйгээрээ илрүүлэн, гал хэмээх хийсвэр махбодын халуун, хурц шинж чанаруудтай адилтгаж, "шар" гэсэн ойлголт, ухагдахуун, нэршлийн дор базан илэрхийлсэн байна. Мембраны альфа төлвөөр зайлшгүй дамжин, дээр дурьдсан биологийн идэвхит бодис, зохицуулгын бүх хүчин зүйлсийн оролцоотойгоор бий болдог дулааны энерги үүсэлт, биемахбодын үйл ажиллагааны идэвхижилт алдагдан, хэт эрчимжсэн болон хэт дарангуйлагдсан үзэгдэл илрэх нь шарын өвчний хэт арвидалт, хэт хорогдолтын талаархи МУАУ-ы ойлголттой тохирдог (2).

Гуравдугаарт: Бүх эд, эсийн ялангуяа митохондри зэрэг энерги нийлэгжүүлэх чадавхитай эсийн доторхи хэсгүүд болон эсийн хуваагдал, нөхөн төлжилтийг хангадаг бүтцийн хэсгүүд (бөөмийн аппарат)-ийн мембран дээр хатуу бетта төлвийн давамгайлал сэдээгдэх үед АТФ үүсэлт, ДНХ, РНХ, уургийн нийлэгжилтэнд оролцдог биологийн идэвхит бодис, гормон, рецептор, фермент, гормон, мессенджерууд уг төлвийн бүтэц-зохицуулгын хүрээнд нягт харилцан үйлчлэлд орж, интеграцчиллагдан, нэгэн чиглэлт тогтолцоот үйл ажиллагааг нэгэн зэрэг гүйцэтгэх боломжоор хангагдсаны гадаад илрэл нь энерги нөөцлөгдөн хуримтлагдах, биеийн жин нэмэгдэх, дулаан үүсэлт хязгаарлагдах, сэрлийн процесс удаашрах, эрүүл, эмгэг хүчин зүйлсийн үйлдлийг мэдрэн хүлээн авах чадвар сулрах, нийт эсийн үйл ажиллагааны идэвхи дарангуйлагдсан байдлыг үзүүлдгийг МУАУ-д ус, шороо хэмээх хийсвэр махбодын хүнд, хүйтэн, мохдог шинж чанаруудтай адилтган, "бадган" гэсэн ойлголт, ухагдахуун, нэршлийн дор зангидан илэрхийлжээ гэж үзэж болох юм (1, 2). Мембраны хатуу бетта төлвөөр дамжигдан, дээр нэрлэгдсэн биологийн идэвхит бодис, уураг, фермент, рецептор, медиаторын оролцоотойгоор явагддаг эсийн хуваагдал, нөхөн төлжилт, энерги нөөцлөлт, АТФ нийлэгжилтийн үйл ажиллагаанд алдагдал илэрч, хэт идэвхижих юм уу? хэт дарангуйлагдах байдал илрэх нь бадган өвчний арвидалт, хорогдолтын талаархи МУАУ-ы онолтой тохирч байгаа нь ажиглагддаг (2).

Өөрөөр хэлбэл мембран нь хүн, амьтны биед харьцангуй том бүтцийн хэлбэрээр оршихдоо зөвхөн төлвөө өөрчлөх замаар нэг тохиолдолд идэвхижүүлэгчийн (альфа), нөгөө тохиолдолд дарангуйлагчийн (бетта) гурав дахь тохиолдолд тэнцвэржүүлэгчийн (гамма) үүргийг дээр дурьдсан бүх биологийн идэвхит бодис, хүчин зүйлсийн хувьд эсийн түвшинд гүйцэтгэдгийг МУАУ-д хий, шар, бадганы онол, ухагдахуунаар илэрхийлжээ гэж хэлж болох юм. Бид "хий, шар, бадган-мембрант байгууламж" шинэ санаа дэвшүүлсэн нь мембран гэсэн гоц гойд зүйлийг гаргаж тавиад, түүнийг эд,эсээс хийгээд фермент, уураг, медиатор, гормон, рецептор зэрэг зохицуулгын бусад хүчин зүйлүүдээс салгасан хэрэг огт бус бөгөөд харин ч биемахбодын үйл ажиллагааны бүх хэлбэрүүд эсийн түвшинд явагдах үед дээрхи хүчин зүйлс нь "гүйцэтгэгч-хөдөлгөгчийн" үүрэг гүйцэтгэн, мембраны гурван төлөв нь тэдгээр харьцангуй саланги чанартай хүчин зүйлсийг бүтэц-үйл ажиллагааны хувьд нэгэн хэлбэршилт-интеграцичилсан байдалд оруулан зохицуулдаг гэсэн байдлаар "эс", "мембран", "фермент,уураг, медиатор, гормон, мессенджерийн тогтолцоо" гэсэн гурван гол зангилгаа зүйлсийг харилцан уялдаа холбоон дунд нь тэнцвэртэйгээр авч үзсэнээрээ ихээхэн онцлог талтай юм. Мембрант байгууламж ийм хүчтэй зохицуулагчийн үүргийг альфа, бетта, гамма гурван төлвөөрөө дамжуулан үзүлдгийн энгийн баталгаа нь фермент, рецептор, уураг, медиатор, гормон, мессенджер, биологийн идэвхит бодисууд тоо, шинж чанарын хувьд ямар ч хувиралт, өөрчлөлтөнд өртөөгүй үед (5) МБ дээр зөвхөн "Mode 1, 2, 3 гэсэн бүтэц-үйл ажиллаганы гурван салангид төлөв-нээгдсэн, хаагдсан, идэвхгүйжсэн гурван хувилбарт байдал" үүсэх нь дээр дурьдсан биологийн идэвхит бодисуудын үйл ажиллагааны эрчмийг хүчтэй идэвхжсэн юм уу? хүчтэй дарангуйлагдсан гэсэн харилцан эсрэг тэсрэг чанартай хэлбэрт оруулдаг үзэгдэл юм (6, 7, 9) .

Ийнхүү амьд биемахбодын түүхэн хөгжлийн явцад эсийн хуваагдал, ДНХ, РНХ, уургийн нийлэгжилт, энергийн солилцоо, АТФ - дулаан үүсэлт, сэрэл-саатлын процессод оролцдог олон тооны биологийн идэвхит бодис, фермент, уураг, рецептор, медиатор зэрэг анхдагч элементийн чанартай зүйлүүд мембран хэмээх өвөрмөц зохицуулагч буюу түгээмэл чанартай анхдагч элементийн түвшинд өвөрмөц харилцан үйлчлэл, тоо, чанар, харьцааны өөрчлөлтөнд орж /8/, интеграцчилагдан, тогтолцоот

байдлыг үүсгэж, бие махбодын эрүүл оршин тогтнохуйн үндсийг бүрэн хангасан үйл ажиллагааг гүйцэтгэдэг зүй тогтолтой болсныг дорно дахины гүн ухаантнууд гадаад олон шинжүүдээр нь танин мэдэж, түүнээс дотоод мөн чанар руу нь хөөн хийсвэрлэх замаар таван махбод, хий, шар, бадганы онолыг гаргажээ гэж хэлж болох юм.

НОМ ЗҮЙ:

1. Амбага.М. (1994) Хий, шар, бадганы онол ба мембрант байгууламж, Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол, УБ, 301 х.

2. Амбага.М., Саранцэцэг.Б. (1995) "Хий, шар, бадган-мембрант байгууламж", УБ, 78 х.

3. Х.Тумбаа хөрвүүлсэн (1991) Анагаах ухааны дөрвөн үндэс, УБ, 735 х.

4. Ред. Д. Дагвадорж, (1995) Гүн ухааны товчоо, 182 х.

5. Крепс.Е.М. (1981) Липиды клеточных мембран, Л.Наука, 340 с.

6. Под.ред. Б.Ткаченко, (1994) Основы физиологии человека, 1 том, Санкт-Петербург, 567 с.

7. Харкевич.Д.А., (1993) Фармакология, М, Медицина, 544 с.

8. Урманцев.Ю.К., (1988) Общая теория систем и проблемы биологической эволюции, в кн: Диалектика познания сложных систем, Мысль, с 155-172

9. Pasternak.С.А., (1985) Cell Surfaces., Interdisciplinary Science Reviews, v.10.no 1. p 42-56

ХАЙРСТ ҮЛДИЙГ (ПСОРИАЗ) МОНГОЛ УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ АРГААР ЭМЧИЛСЭН ТУХАЙ

Б.Энхбаяр, Ч.Долгор, Б.Дагвац р н
Ардын эмнэлгийн хүрээлэн, Анагаах Ухааны Их Сургууль

Хайрст үлд (псориаз) нь дэлхийн олон оронд тархмал тохиолддог, үндсэн шалтгаан, эмгэг жам нь төдийлөн сайн тогтоогдоогүй, дахилт олонтой, эмчлэхэд төвөгтэй өвчин юм.

Манай оронд олон жилийн ажиглалтаар арьсны өвчнүүдийн дунд насанд хүрэгчдэд 2,5-5,2 % буюу тохиолдлын тоогоороо, арьсны халдваргүй өвчнүүдийн дотор 3-4-р байр эзэлдэг гэж үзжээ.

Хайрст үлд бол манай тооллын өмнөх үе 4000 жилийн тэртээ PSORA гэдэг нэртэйгээр бичигдэж байсан бөгөөд дорно дахины болон монгол уламжлалт анагаах ухааны олон ном сударт арьсны өвчнийг үндсэн 10 өвчнөөр тоолж түүний дотор үлд өвчнийг авч үзсэн байдаг.

МУАУ арьсны янз бүрийн өвчнийг эмчилж ирсэн баялаг уламжлалтай бөгөөд хайрст үлдтэй төстэй өвчний шалтгааныг биеийн шар усны өөрчлөлттэй холбон авч үзэж ирсэн байна. Хайрст үлдийг сүүлийн үед бүх биемабод-тогтолцооны шинжтэй өвчин гэж үзэж, үе шат явцаас хамааран төв ба зах хязгаарын мэдрэлийн систем, дотоод шүүрлийн булчирхай, өөх тосны, нүүрс-усны, уургын, дархлал зэргийн өөрчлөлт гарч байгааг батлан бичжээ. Хайрст үлд өвчнийг МУАУ зүү, төөнүүр, хануур, эм, шавар, шавшилга зэргээр эмчилж ирсэн ариун уламжлал байдаг.

Бид энэ удаа арьсны янз бүрийн өвчин эмгэгийг эмчлэхэд хэрэглэж байсан зарим уламжлалт аргуудын талаархи мэдээ баримтыг нягтлан авч үзсэний дүнд тэмээний шээс, түүнийг оруулсан хэлдмэлийг сонгон авч хайрст үлд өвчтэй цөөн тооны хүмүүст бэрэглэн клиникийн ажиглалт судалгаа явуулсан ажлынхаа урьдчилсан дүнг үзүүлж байгаа юм. Нийт 15-55 насны 10 өвчтөнийг судалгаанд хамруулав. Үүнээс эмэгтэй-5, эрэгтэй-5, үүнээс 15-20 насанд-5, 20-30 насанд-3, 40 ба түүнээс дээш насанд -2 өвчтөн байв. Эдгээрээс анх удаа хэвтэж эмчлүүлсэн -5 бусад нь давтан эмчилгээ хийлгэсэн байна. Дээрхи өвчтнүүдэд хайрст үлдийн байрлалыг авч үзвэл: дээд, доод мөч, цээжээр тууралттай-2, тууралт бүх биеэр (толгой үстэй хэсгийн хамт) байрлалтай-7, зөвхөн тохой, өвдөг, толгой нүүрээр гарч эхэлсэн-1 өвчтөн байв. Гарсан голомтуудад ганц нэг гүвдрүүтэй тохиолдол 3 эрэгтэй, 4 эмэгтэйд ажиглагдсан. Хайрст үлдийн хөрзөнтэй (блящечный) тууралт 2 эрэгтэйд тохиолдсон ба шүүдэст (экссудативный) хэлбэр 1 өвчтөнд илэрсэн. Үе шатаар нь ялгавал: давших (прогрессивный) шатандаа байгаа 7, (эр-2, эм-5), зогсонги үедээ (стационарный) орсон 3 өвчтөн байв. Эмчилгээнд тэмээний шээсний бэлдмэлийг гадуур хайрст үлдийн голомтонд түрхэх, шавших замаар хэрэглэсэн. Өвчтнүүд энэ үеэр хоол

унд,ажил хөдөлмөрийн ердийн дэглэм барьж байсан. Эмчилгээг өдөрт 2 удаа өглөө эрт ба орой унтахын өмнө хийв. Дээрхи эмчилгээг хийхэд хайрст үлд өвчний голомт буюу гарсан язгуур эд нь 8-10 хоногийн дотор шимэгдэн багасаж эхэлсэн.

Эхний 1-3 хоногт загатнаа улам нэмэгдэж байсан боловч эмчилгээг үргэлжлүүлэн хэрэглэхэд 5 дахь хоногоос загатнаа намдаж алга болов. Гарсан элементийн гуужилт ихсэж, улайлт нь бүдгэрч, үлдийн элемент нимгэрч зогсонги үедээ шилжин алга болох төлөвт орлоо. Энэ үед эр-3, эм-2 өвчтний голомтууд нь хэт хуурайшин арьс нь хагарч байв.

Ийм тохиолдолд 2 янзын тос түрхэж үзлээ. Үүнд: 2 %-ийн салицилийн хүчил ба тэмээний чөмөгний тос тус тус түрхэхэд тэмээний чөмөгний тос илүү үр дүнтэй нь ажиглагдаж байлаа. Эмчилгээг нийтдээ 7-14 хоног хэрэглэв. Үүнээс хайрст үлдийн тууралтын элемент нь алга болсон-7, сайжирсан-3 өвчтөн байсан.

Дүгнэлт.

1.Тэмээний шээсээр голлон бэлтгэсэн бэлдмэл нь хор гаж нөлөөгүй бөгөөд псориаз өвчний янз бүрийн үед, хэлбэр шатандаа байгаа өвчтөнд зохих үр дүнтэй болох нь бидний урьдчилан явуулсан судалгааны дүнгээс харагдаж байна.

2. Цаашид судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэхдээ орчин үеийн анагаах ухааны ололтонд түшиглэн МУАУ-ны аргыг харьцуулан үзэх ба эмчилгээнд хэрэглэсэн тэмээний шээс, түүний бэлдмэлийн тал бүрийн шинжилгээг төгс хийж-хэрэглэх аргын үндэслэл гаргах хэрэгтэй байна.

Ном зүй

1. Ч. Долгор. (1980). Псориаз өвчний тархалт, эмнэл зүйн судалгаа. АУ докторын зэрэг горилсон диссертац. х 302.
2. Анагаах ухааны дөрвөн үндэс. (1991). Улаанбаатар.
3. С.Т.Семушкин. (1949). Диагностика заболеваний верблюдов. М.Мед. с 200.
4. Чойжамц. (1991). Маш гайхамшигт хуримын сан. Улаанбаатар. х 82—83.

ШОХОЙН ЖОНШ, ТҮҮНИЙ БҮТЭЦ, НАЙРЛАГА

Т.Ганбаатар, Л.Мягмар
Геологи, Эрдэс Баялагийн Хүрээлэн,
Анагаах Ухааны Их Сургууль

Түвд, Монголын уламжлалт анагаах ухаанд ургамал, амьтан, эрдсийн гаралтай байгалийн түүхий эдийг эмэнд өргөн хэрэглэж ирсэн билээ.

Эдгээрийн дотроос эрдсийн гаралтай эмт бодисын нилээд түгээмэл төрөл болох жоншны зарим зүйлд бид судалгаа хийлээ.

"ЖОНШ" гэдэг нь "эмт чулуу" гэсэн түвд үгнээс гаралтай бөгөөд түвд, монгол эмнэлгийн эх судруудад эр, эм, саармаг (манин), охин, хөвгүүн гэсэн 5 зүйл болгон эмийн жоронд хэрэглэж ирснээс, эр жонш буюу шохойн жонш (түвдээр-по жонш)-ийг хамгийн сайн чанартайд тооцдог байжээ (1,2,3,4, 7).

Манай ууган оточ Ханчин-чойжил-Лувсанданзанжанцангийн "Язгуур үндсийн тайлбар" сударт (8): "...Хичнээн дахин хагалавч дөрвөлжин хэлбэрээр хагардаг, молор лугаа адил хатуу хунд, шил мэт тунгалаг төрөл хамгийн эрхэм сайн хийгээд, өөхөн чулуу адил нь чанараар муу...) гэж тэмдэглэгдсэн бол Жамбалдорж (5) "Анагаах үйлдэх аршааны таван шимийг эндүүрэлгүй танин барих толь, асар үзэсгэлэнт нүдний чимэг..." бүтээлд жоншийг "Чулууны шим", "Орчлонгийн шимийн хураангуй", "Бодь сэтгэлийн цагаан" гэсэн (6) онч нэрээр уламжлалт эмнэлэгт хэрэглэдэгийг дурьдаад, төрөл зүйл бүрийн шинж төрх, эрдэм чадлыг бичиж, зурж дүрсэлсэн байдаг. Бид судар бичигт тэмдэглэгдэж үлдсэн монгол орны болон шинээр олдсон шохойн жонш бүхий газруудаар ажиглалт хийж, микроскоп, рентген бүтцийн шинжилгээ, эрдэс төрүүлэгч эх уусгамлын оромыг ажиглах, дулааны нөлөөлөлд үзүүлэх чанар хийгээд хими, солонгон задлалын зэрэг эрдэс судлалын орчин үеийн аргаар судалгааг явууллаа. Микроскоп, рентген бүтэц, дулаан "ромбоэдр" хэлбэрээр төгсгөлгүй хуваагддаг, шохойлог тунамал бөгөөд галт уулын хүрмэн чулуулагуудын дотор бага зэргийн дулааны горимд (146-164 хэмд) царцаж талст хэлбэрээр үүссэн бараг цэвэр "КАЛЬЦИТ"-ын төрлийн эрдэс болох нь тогтоогдлоо.

Химийн нарийвчилсан шинжилгээгээр газар бүрээс авсан дээжийн найрлага, нүүрс хүчлийн кальцийн нийт хэмжээ 92,5

%, цахиурын исэл / SiO_2 /-0,89, магнийн/ MgO /-0,37, манганийн / MnO /-0,6 % болон төмөр, хөнгөн цагаан, кали, фосфор зэрэг ислүүд үлдсэн хувийг эзлэж байв.

Харин солонгон задлалын шинжилгээгэр шохойн жоншны найрлаганд титан-0,002, манганий-0,02, хром-0,001, никель-0,00016, кобальт-0,0005, ванадий-0,001, молибден-0,0001, зэс-0,001, хар тугалга, цайр, цагаан тугалга-0,002, барий-0,01, цирконий-0,005, мөнгө-0,00001 хувиар байгаа нь тогтоогдов.

ЭНЭ СУДАЛГААНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭС ДҮГНЭЛТ ХИЙХЭД:

Уламжлалт анагаах ухааны судруудад эр жонш хэмээн нэрлэдэг эрдэс нь эрдэс судлалын орчин үеийн ангилалаар карбонатуудын ангийн кальцит-арагонитын бүлгийн эрдэс болох исланд жонш юм.

Уг эрдэс байгаль дээр ихэвчлэн тунгалаг өнгөтэй тохиолдох боловч агуулагдаж байгаа хольц элементээс хамаарч шаравтар, ягаан, хөхөвтөр туяатай байна.

Судалгаанд хамрагдсан шохойн жонш нь шохойн чулуу болон галт уулын хүрмэнд, гэсэн 2 нөхцөлд үүссэн бөгөөд хүрмэнд үүссэн шохойн жоншны найрлаганд манганийн хэмжээ илүү байгаа нь ажиглагдлаа.

Ном зүй

1. Баавгай Ч. Болдсайхан Б. (1990). Монголын уламжлалт анагаах ухаан. Улаанбаатар. х 175-176.

2. Бетехетин А.Г. (1961). Курс минерология. Госгеотехиздат. М. с 34-39

3. Ганбаатар Т. Оюунчимэг Н. (1993). Монголын уламжлалт эмнэлэгт хэрэглэдэг зарим эрдэс. ЭША-ын тайлан. Улаанбаатар

4. Костов. И. (1971). Минерлогия мира. М. с 96-99

5. Жамбалдорж. XIX зуун. Анагаах үйлдэх аршааны таван шимийг эндүүрэлгүй танин барих толь, асар үзэсгэлэнт нүдний чимэг. х 42-43

6. Лувсанчүлтэм. XIX зуун. Шороо, чулуун эмийн зүйл. х 24-26

7. Хайдав Ц. Шерхан О. (1975). Монгол ардын эмнэлэгт хэрэглэж байсан зарим эрдэс. Улаанбаатар. х 112-114

8. Ханчин-Чойжил- Лувсанданзанжанцан. XVII зуун. Язгуур үндсийн тайлбар. х 43-45

ABSTRACTS:

**INFLUENCE OF MEMBRANE STATES ON THE INTENSITY
OF IMMUNOTROPIC ACTIVITY OF SOME MEDICAMENTS**

**B.Sarantsetseg, P.Bolormaa, M.Chultemsuren,
M.Ambaga, T.Dolgorsuren**
*National Institute of Traditional Medicine MOH,
Mongolian National Medical University*

In the result of experiments, conducted in the Mice we are revealing that "immunodeficiency state" caused by increase of beta state of Membrane structure (MS) decreased under influence of *Salsola larcifolia*, *Oxytropis myriophyllia*, which appeared in the forms of increase of spleen index in 1,6-1,8 times, the number of spleenocytes in 1,2-1,35 times, hemaagglutinin titer in 1,65-2,1 times, the action mechanism of such effects explained by induction of beta-alpha state transition in MS. Also our investigations showed that the water extractions of *Salsola larcifolia*, *Oxytropis myriophyllia* in case of modifying of alpha state of MS increased the spleen index in 1,2-1,22 times, the number of spleenocytes in 1,2-1,22 times, the hemaagglutinin titer in 1,22-1,25 times, mechanism of these effects may be explained by antioxidant-membranestabilizing activity of preparations.
pp. 3-8; References 14.

**STUDY OF TRADITIONAL PRESCRIPTIONS FOR IMPROVEMENT OF BODY
RESISTANCE BY TREATING KIDNEY**

T.S.Varlamova B.Dagvatseren
*National Institute of Traditional Medicine,
Ministry of Health Mongolia*

The comparative study was carried out on *Elletarium Cardamum* and preparation "Tsinaspol" which adaptogenic effect has been determined before. The experiment showed that "Tsinaspol" similar to *Elletaria cardamum* preparation possess antistress action, and stimulation adaptogenic effect. This is also explained in Mongolian traditional medicine as tonic for Kidney and is widely used for improving the body potency.
pp. 8-10; References 8.

**COMPARATIVE STUDY OF THE BIO-ELECTRICAL ACTIVITY OF THE
BLOODLETTING POINT OF VEINS**

N.Tumurbaatar
*Department of the Mongolian Traditional Medicine,
Medical University*

The special method of therapy in the Mongolian Traditional Medicine by opening the venous blood-vessel from different part of the body and taking out some blood is known as "correction of the blood circulation"

The author has discovered that the transmission of electricity through this point is high where as its resistance is low in comparison to the neighbouring tissues. That is a valuable contribution to the development of the Mongolian traditional medicine.

We conducted the study of the electrical activity of the point among 35 healthy, 41 patients with Pyelonephritis, 20 patients with chronic Hepato-biliary disorders, totally 96 person were involved.

The Bio-electrical activity was studied with the help of "Neurometer", Japan. The Bio-electrical activity of a normal person at the upper extremities of the body is higher than the other part. However the Bio-electrical activity of the above mentioned patients is lesser by ($P < 0.05$) upper extremities and ($P < 0.01$) lower extremities compared to the normal people.

Conclusion:

1. Veins are not only vessels of blood circulation but also transmitters of Bio-

electrical energy to the whole body.

2. The change of Bio-electrical activity of the pointv give a new approach to determine the course of a disease as well as to diagnose it.

pp. 11-13. References

PHYTOCHEMICAL AND PHARMACOLOGICAL INVESTIGATION OF IRIS TENUIFOLIA PALL

**G. Purevsuren, O. Purev. M. Ambaga, B. Sarantsetseg, Ch. Tserennadmid,
Z. Oyun**

National Institute of Traditional Medicine MON

In the result of phytochemical investigation carried on *Iris tenuifolia* Pall we are revealed the existence of two new flavonoids, which did not registered before. Pharmacological studies shows that water extract, obtained from *Iris tenuifolia* exerted immunodepressant effect and such activity may be is due to new fraction, which possessed prooxidant action.

pp. 14-18; Tables 2; Pictures 2; References 7.

THE PHARMACOLOGICAL STUDY OF ASTRAGALIS ADSURGENS ON CARDIOVASCULAR SYSTEM

P. Bathuyag, L. Mlagmar
National Medical University

The pharmacological action of preparation from *Astragalus* Pall (Extractum and Tinctura) *adsurgnis* gens was studied at various doses i.v. (0,01g/kg, 0,02 g/kg, 0,04 g/kg, 0,048 g/kg) on hare. The results shows that preparations decrease blood pressure in 22.41-62.50 %, during 50-120 minutes and that effect has adrenolitic properties.

pp. 18-20; References 7.

ON MAIN PRINCIPALS OF THEORETICAL BACKGROUND OF PULSE FEELING OF THE MONGOLIAN TRADITIONAL MEDICINE

Sh. Bold, M. Ambaga
*National Institute of Tradotional Medicine Minstry
of Health Mongolia*

Specific changes occurred in Basic state of Membrane structure (MS) during concrete season is exerted the regulatory influence on functional activity of five solid organs depending their specificity of membrane by increasing the function of one organs and decreasing the function of another organs. The prevalence of beta-state of MS in spring season leads to stabilization of M^α of hepatocytes which is expressed in the theory of MTM as improvement of Liver pulse, but such changes of MS accompanied by increase of beta state in MS of Lung and decrease of lung function characterized in the theory of MTM as decline of pulse of lung-enemy to liver organ. pp. 21-22; References 9.

"HII, SHAR, BADGAN" AND SOME BASIC LAW-GOVERNING NATURE OF THE ORGANISM

B. Dagvatseren
National Institute of Traditional Medicine Ministry of Health Mongolia

The author studied the main theoretical conceptions of Mongolian and Tibetan traditional medicine. He utilized the method and approach of the modern system structural analysis.

This showed that the "Hii, shar and badkan" of traditional medicine exactly corresponds to the "First universag quality" /or first elements/ of the Human "body-system" In consequence, the author found in the conceptions theory and the

methodology of traditional medicine following general laws;

1. I and II transformation laws of the "object system",
2. The law of isomorphism and polymorphism
3. General principles of harmony and perfecty

This gives him possibility to develop a new "Unit intergative theory and methodology of medicine about the interrelation and coordinated action between the " organism-system and the environments.
pp. 25-32; References 13.

PHILOSOPHICAL PROBLE MS THE NEW CONCEPTION "HII, SHAR, BADGAN - MEMBRANE STRUCTURE"

M.Ambaga, B.Sarantsetseg

National Institute of Traditional Medicine Ministry of Health Mongolia

In the result of using of Methodological approach "Inner essence, substance-various external properties-abstract notion" we came to conclusion that in the of Mongolian Traditional Medicine (MTM) under the abstract notion "Shar" summarized and symbolized the existence of Substance on Human organism which enable to produce Hot, Light, Acute characteristics-external properties, this according to Oriental philosophy (O.Phil) is formed in during of function of abstract element "fire". We reveal that the role of Such Substance on Human body can play heatenergy-generating alpha state of Membrane structure (MS). The abstract notion "badgan" summarized the existence of Substance on Human organism, which enable to create Heavy, Cold characteristics-external properties, this according to O.Phil formed in the result of function of abstract elements "water and earth".

We conclude that the role of Such substance can play energygenerating, energyaccumulating solid beta state of MS.

As regard to abstract notion "Hii, it symbolized and showed the existence of Substance on human organism which enable to create Light, Mobile characteristics-external properties, this according to O.Phil formed in the result of function of abstract element "Hii". We can say that the role of Such substance can play "excitable" Gamma state of MS.

pp. 32-38; References 9.

TREATMENT OF PSORIASIS BY METHODS OF MONGOLIAN TRADITIONAL MEDICINE

B.Enkhbayar Ch.Dolgor, B.Dagvatseren

National Institute of traditional Medicine Ministry of Health Mongolia, National Medical University

The clinical studies on 10 patients with psoriasis was conducted. It found that under the influence of preparation including camel's urine occurred patterns of normalizing of disease in form of thinning pathologic tissues and disappearing of the colour of damaged skin after 5-8 days of the treatment.

pp.38-40.

CALCIDUM AND IT'S STRUCTURE AND COMPOSITION


T.Ganbaatar L.Miagmar

National Medical University

The island spar (calcium, in Tibet-po Jongshi), which had been used traditional medicine, is called according to the contemporary classification of minerology as island spar.

The result of our analyses shows that the calcium is rich in CaO (towards 92 %) and calcium has high content of MnO (towards 22,4 %).

pp. 40-41. References.8



МОНГОЛЫН АНАГААХ УХААН СЭТГҮҮЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮД

П.Нямдаваа (Ерөнхий эрхлэгч), Б.Дэмбэрэл (Орлогч эрхлэгч),
Ш.Доржжадамба (Орлогч эрхлэгч), В.Хадхүү (Хариуцлагатай
нарийн бичгийн дарга), Р.Арслан, Ж.Батсуурь, Б.Гоош,
А.Ламжав, Э.Лувсандагва, Ө.Өлзийхутаг, Т.Тойвгоо, Ц.Хайдав,
Ж.Шагж, Б.Шижирбаатар, Г.Цагаанхүү.

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

С.Алтан (АНУ Нью Жерси), Д.Балдандорж, М.Грегт (АНУ,
Миннесота), Б.Дагвацэрэн, Ж.Дашдаваа, Б.Доржготов, Б.Жав,
Ш.Жигжидсүрэн, Г.Зориг, Т.Зориг, Г.Лувсан, (Оросын холбоо,
Москва), Д.Малчинхүү, Н.Мөнхтүвшин, Ц.Мухар,
Б.Нацагдорж, Ц.Норовпил, П.Онхуудай, Э.Пүрэвдаваа,
Б.Рагчаа, Э.Санжаа, Г.Сүхбат, С.Цоодол, Л.Шагдар

МАНАЙ ХАЯГ:

Улаанбаатар-210648, ЧИНГЭСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ
"Эрүүл Энх" хэвлэлийн газар Утас: 321307

Техник редактор Ө.Бямбажаргал

Сэтгүүлийн компьютерт 12 сард бэлтгэж хэвлэлтэд шилжүүлэв.

Цаасны хэмжээ 60 x 90 1\16 хэв. хуудас 3.00